



**Аудитыг гүйцэтгэсэн:
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН
ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор:

М.Давааням

Менежер: 3.Ариунзаяа

Ахлах аудитор: Д.Ганбилэг

Гэрээт ажилтан:

Ш.Наранбаатар
Р.Чулуунзагд

Гэрээгээр хамтран ажилласан: “Есөнхангай аудит” ХХК

Уг тайланг УАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү.
www.audit.mn

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261456 дугаарын утсаар харилцана уу.

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёо	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	4
Ерөнхий мэдээлэл	6
Бүлэг 1. Компанийн удирдлагын зарим үйл ажиллагаа хууль тогтоомжтой нийцээгүй, батлагдсан орон тоог хэтрүүлэн ажиллаж ирсэн байна.	
Компанийн бүтэц, орон тоо, чиг үүрэг, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хяналгүй баталсан байна.	7
Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрдүүлэх, гүйцэтгэх удирдлагыг томилоход холбогдох хууль тогтоомжийг баримтлаагүй байна.	8
Бүлэг 2. Компанийн зарим хөрөнгө нөөц, үйл ажиллагааны зардлыг хэмнэлттэй зарцуулаагүй, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.	
Компанийн ашгийн хэмжээ 2017 онд өмнөх оноос нэмэгдсэн ба орлогын дийлэнх хувийг зорчигч тээврийн орлогоос бүрдүүлсэн байна.	10
Компани нь орлого нэмэгдүүлэх, онгоцны сул зогсолт гаргахгүйн тулд нойтон түрээсийн үйлчилгээг үзүүлж байна.	11
“Mega Global Air Services” компани нь нойтон түрээсийн үйлчилгээний төлбөрөө бүрэн төлөөгүйгээс авлага үүссэн байна.	12
Шатахуун нийлүүлэх бусад компаниудад өрсөлдөх боломж олдохгүй байх нөхцөл үүсжээ.	14
Хөрөнгө оруулалтын болон худалдан авалтын төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулаагүй байна	17
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчин шууд гэрээ байгуулжээ.	17
Агаарын хөлгийн сэлбэг худалдан авах ажиллагаа нь өөрийн онцлогтой тул хуулийн орчныг сайжруулах шаардлагатай байна.	17
Төлөөлөгчийн газрууд зардлаа батлагдсан төсвөөс 942.3 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.	18
Бараа солилцооны болон худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүйгээс зардал дутуу илэрхийлэгдсэн байна.	19
Эвлэрлийн гэрээ байгуулахыг урьтал болгосон нь компанийг өр төлбөрт оруулах нөхцөл болсон байна.	20
Хөрөнгө оруулалтын болон худалдан авалтын төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулаагүй байна.	21
Урт болон богино хугацаат зээлийн эргэн төлөлттэй холбоотойгоор жил бүр ханшийн алдагдал үүсэж байна.	22
Түрээсийн төлбөр нь насжилт, хугацаа, багтаамж зэргээс хамаарч харилцан адилгүй байна.	24
Катеринг төвийн удирдлагын үндсэн гэрээний хугацаа дууссан байхад нэмэлт гэрээ байгуулсан, барьцаа төлбөрийг үндэслэлгүйгээр буцаан олгосон байна.	24
Бүлэг 3. Компанид өмнө нь хийгдэж байсан хөндлөнгийн хяналт шалгалтууд түүний мөрөөр авсан арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна	25
“Боинг 737-800” агаарын хөлгийн ослын улмаас хөдөлгүүр эвдэрсэн ба засвар хийлгэх хугацаанд шинээр нэмэлт хөдөлгүүр түрээслэн авч төлөвлөгдөөгүй зардал гаргажээ.	26
Компанийн өр төлбөрийг төлж барагдуулахад шаардагдах санхүүгийн нөөц хүрэлцэхгүй байна	27
Холбогдох байгууллагын санал	29
Саналд өгсөн тайлбар	30
Дүгнэлт	31
Зөвлөмж	33
Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал	35
Хавсралт	38



Товчилсон үгийн жагсаалт

МИАТ	Монголын Иргэний Агаарын Тээвэр
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИНЕГ	Иргэний Нисэхийн Ерөнхий Газар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
УИХ	Улсын Их Хурал
ХБ	Хөгжлийн банк
СЯ	Сангийн яам
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
БНЧУ	Бүгд Найрамдах Чех Улс
БНМУ	Бүгд Найрамдах Малдив Улс
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨХ	Төрийн өмчийн хороо
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ЗГ	Засгийн газар

Хүснэгтийн товъёог

Хүснэгт-1 Компанийн санхүүгийн үндсэн үзүүлэлт.....	хуудас 10
Хүснэгт-2 Агаарын хөлгийн нойтон түрээсийн гэрээнд заасан нислэгийн хугацаа, блок цаг, төлбөрийн хэмжээний мэдээлэл.....	хуудас 11
Хүснэгт-3 B767-FGN агаарын хөлгийн нойтон түрээсийн зардлын үзүүлэлт.....	хуудас 11
Хүснэгт-4 Агаарын хөлөг тус бүрийн орлого, зарлага, ашиг.....	Хуудас 12
Хүснэгт-5 Ачаа тээвэрлэлтийн үзүүлэлт.....	Хуудас 12
Хүснэгт-6 Нислэг, тээвэрлэлтийн үзүүлэлтүүд.....	Хуудас 12
Хүснэгт-7 УБ-Сөүл-Бусан чиглэлийн зах зээлд эзлэх хувь.....	Хуудас 13
Хүснэгт-8 Шатахууны үнийн үзүүлэлт.....	Хуудас 14
Хүснэгт-9 Сургалтын задаргаа.....	Хуудас 16
Хүснэгт-10 Авлагын үзүүлэлт.....	Хуудас 16
Хүснэгт-11 Өр төлбөр.....	Хуудас 16
Хүснэгт-12 Худалдан авсан сэлбэгийн дүн, засварын тоо.....	Хуудас 20
Хүснэгт-13 Урт хугацаат зээл.....	Хуудас 21
Хүснэгт-14 Зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэр.....	Хуудас 21
Хүснэгт-15 Зээлийн эргэн төлөлт ба хуваарь.....	Хуудас 22
Хүснэгт-16 Түрээсийн мэдээлэл.....	Хуудас 22
Хүснэгт-17 Агаарын хөлгийн түрээсийн төлбөрт төлсөн дүнг онгоц тус бүрээр.....	Хуудас 23
Хүснэгт-18 Компанийн хөрөнгийн бүрэлдэхүүний динамик шинжилгээ.....	Хуудас 26
Хүснэгт-19 Төлбөрийн чадварын шинжилгээ.....	Хуудас 27
Хүснэгт-20 Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ.....	Хуудас 27
Хүснэгт-21 Эргэцийн шинжилгээ.....	Хуудас 27
Хүснэгт-22 Хөрөнгө капиталын ачааллын шинжилгээ.....	Хуудас 28
Хүснэгт-23 Ашигт ажиллагааны шинжилгээ.....	Хуудас 28
Хүснэгт-24 Мөнгөн урсгалын шинжилгээ.....	Хуудас 28

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын Хорооны 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2018 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.
Аудитын зорилт	“МИАТ” ТӨХК-ийн 2016-2017 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитыг дараах зорилтын хүрээнд төлөвлөж, хэрэгжүүлсэн болно. Үүнд: <ul style="list-style-type: none">• Компанийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн удирдан, зохион байгуулсан эсэх,• Компанийн хөрөнгө нөөцийг үр ашигтай удирдаж байгаа эсэх,• Компанийн үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитын төлөвлөгөөнд тусгасан асуудлаар “МИАТ” ТӨХК-ийн 2016-2017 оны санхүүгийн болон бусад баримт материалыг хамруулан шалгасан бөгөөд аудит хийх цаг хугацаа богино, ажлын цар хүрээ их тул ачаалалтай ажиллаж зарим ажил гүйлгээг нэг бүрчлэн үзэх боломжгүй байсан. Иймд аудитыг мэдээллийн эх сурвалж, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрөөр багийн бүрэлдэхүүн, ажлын цар хүрээг нарийвчлан тогтоож өгсний дагуу гүйцэтгэсэн болно. Тус компанийн харьяа нэгж, газар, хэлтсээс холбогдох материалыг гаргуулах, тайлбар, тодруулга авах зэрэг ажилбарууд хийгдсэн болно.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхдээ холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашигласнаас гадна Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журамд заасан аргачлалыг мөрдөн аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.
Аудитын бүрэлдэхүүн	Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор М.Давааням удирдаж, аудитын менежер З.Ариунзаяа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор Д.Ганбилэг, гэрээт ажилтан Ш.Наранбаатар, Р.Чулуунзагд нар гүйцэтгэсэн бөгөөд аудитын хамрах хүрээний зарим асуудлыг шалгуулахаар “Есөнхангай аудит” ХХК-тай гэрээний үндсэн дээр хамтран ажилласан болно. Аудитад мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх дээрх зөвлөх үүрэгтэй баг нь мөнгөн хөрөнгийн гүйлгээ, үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт, түүний эх үүсвэр, төлөөлөгчийн газруудын ачаа тээвэр, зорчигчийн тийзийн борлуулалтын орлого, борлуулагч агентууд, худалдан авах ажиллагаатай холбоотой баримт материалыг нягталж үзсэн. Түүнчлэн хөрөнгө оруулалт, бараа солилцооны авлага, өглөг /урт болон богино хугацаатай зээл/-ийн тооцоололд нэмэлт горим гүйцэтгэж асуудлын нөхцөл байдал, учир шалтгаан, үр дагаврын болон санхүүгийн тайлангийн шинжилгээ хийлээ.
Аудитын хугацаа	Аудитын баг 2018 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс 2018 оны 3 дугаар сарын 28-ныг хүртэл талбар дээр ажиллаж, 2018 оны 4 дүгээр сарын 1-нийг хүртэлх хугацаанд аудитаар илрүүлсэн зүйлсэд дүн шинжилгээ хийх, баримтжуулах, аудитын дэд тайлангийн төсөл бэлтгэх, нэгтгэх ажлыг хийсэн болно.

Хүндрэл
бэрхшээл

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээлэл, судалгааг гүйцэтгэлийн аудитын журмын дагуу бэлтгэж, ажлын баримт материалд хавсаргалаа.

Аудитын явцад учирч байсан дараах хүндрэл бэрхшээлтэй асуудлуудад компанийн удирдлага анхаарлаа хандуулж, нөхцөл шалтгааныг судалж, шийдвэрлэх нь зүйтэй. Үүнд:

- Зарим ажилтнууд шаардлагатай баримт материалыг тогтоосон хугацаанд шуурхай гаргаж өгөх талаар идэвх санаачилгагүй хөшүүн хойрго хандсан, хууль, хяналтын байгууллагаас хийж байгаа бусад шалгалт тус аудиттай давхцаж байсан нь цар хүрээ өргөн асуудлыг тогтоосон богино хугацаанд гүйцэтгэхэд ихээхэн хүндрэл учруулж байв.
- Аудитын явцад нэг ижил төрлийн баримт, мэдээ, судалгааг 2 өөр хэлтэс буюу бусад эх үүсвэрээр гаргуулан авахад хоорондоо зөрүүтэй байх тохиолдол их байсан нь мэдээ, тайлангийн чанар, найдвартай байдалд нөлөөлж цуглуулсан тоо мэдээлэл, баримт нотолгоог олон дахин нягтлах, баталгаажуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийхэд ихээхэн цаг хугацаа шаардагдаж байсан нь аудитын хугацаа алдах шалтгаан болж байлаа.
- Боловсон хүчний тогтвор суурьшил муу, тэдгээрийг сонгон шалгаруулсан холбогдох материал байхгүй, хүний нөөцийн програм хангамжийн ашиглалт хөгжүүлэлт муу байгаа нь хүний нөөцийн эргэц болон бусад тооцоог нэг бүрчлэн шалгахад хүндрэлтэй байсан болно.
- Тус компани санхүү, нягтлан бодох бүртгэл, бизнесийн үйл ажиллагааг бүхэлд нь нэгтгэж, удирдах зорилгоор **Microsoft Dynamics Nav** програмын 2016 хувилбарыг ашиглаж санхүүгийн тайлан тэнцэл гаргадаг. Тус санхүүгийн програмыг өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлээгүй нь шаардлагатай мэдээлэл, тайлан гаргуулж авахад хүндрэлтэй, цаг хугацаа алдах шалтгаан болж байсан.



Ерөнхий мэдээлэл

Монгол Улс өргөн уудам нутагтай, далайд гарцгүй орны хувьд гадаад улсуудтай холбох гүүр болох иргэний нисэхийн салбар нь үндэсний аюулгүй байдлын тулгуур хүчин зүйлийн нэг юм.

Анхны иргэний агаарын тээврийн үйлчилгээний эх суурийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1946 оны 27 дугаар тогтоолоор тавьсан бөгөөд тухайн үеийн “МИАТ” компанийн дотоод болон гадаад үйл ажиллагаа өргөжин тэлж 1996 онд Олон Улсын Агаарын Тээврийн Холбооны (ИАТА) гишүүн болж 2012 онд үйлчилгээний түвшинг Английн Скайтракс (Skytrax) судалгаа үнэлгээний байгууллагаас 3 одтой зэрэглэлийн хэмжээнд хүрснийг албан ёсоор зарлажээ.

Тус компани хүнд даацын өргөн их биетэй 258 суудалтай 1ш Боинг 767-300 ER маягийн шинэ агаарын хөлгийг 2013 онд зээлээр худалдан авч, түрээсээр 220 суудалтай 1 ш Боинг 767-300, 162 суудалтай 3ш Боинг 737-800, 126 суудалтай 1ш Боинг 737-700 нийт 6 агаарын хөлөгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

“МИАТ” компани нь 100 хувь төрийн өмчит хувьцаат компани бөгөөд Ази, Европын болон олон улсын 8 чиглэлд тогтмол, орон нутгийн 1 чиглэлд захиалгат нислэг хийж, жилд дунджаар 400.0 гаруй мянган зорчигч, 3.0 мян.тонн ачаа тээвэрлэн нийт 9.0 мянга орчим цагийн нислэг үйлдэж байна.

Монгол Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ыг баталж, “МИАТ” ТӨХК-ийг үндэсний тээвэрлэгч компани байхаар шийдвэрлэсэн бөгөөд уг баримт бичигт түүний ирээдүйн чиг хандлага, бизнес стратегийг төлөвлөх үндэслэл болсон төдийгүй дээрх тогтоолд компанийн үнэлэмжийг дээшлүүлэх, агаарын хөлгийн парк шинэчлэлтийг төрөөс дэмжих, татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг чухал ач холбогдолтой заалтууд оржээ.

“МИАТ” ТӨХК-ийн удирдах дээд байгууллага нь хувь нийлүүлэгчдийн хурал бөгөөд хувь эзэмшигч нь Монгол Улсын Засгийн газар юм. Тус компани гүйцэтгэх захирал, нислэг үйлдвэрлэл эрхэлсэн тэргүүн дэд захирал болон бусад 3 дэд захиралтай бөгөөд аюулгүй ажиллагаа, чанар, нисэхийн аюулгүй байдлын алба, 2 тасаг, 19 хэлтэстэй, харьяа 1 төв /авто бааз/, 6 Төлөөлөгчийн газарт нийт 879 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулж байна.

Компани нь 2017 оны байдлаар нийт 20 борлуулагч агенттай хамтран ажилладаг бөгөөд томилогдсон борлуулагч агентууд нь компанийг тухайн бүс нутагт төлөөлөн шууд борлуулалт хийдэг байна.

Зорчигчийн тарифыг олон улсын стандартад нийцүүлэх, орлогын менежментийн үйл ажиллагааны нөхцөлийг хангах зорилгоор 2017 оны эцэст олон улсын билет захиалгын “Amadeuse Altea систем” програмын шинэчлэлийг хийжээ.

Бүлэг 1. Компанийн удирдлагын зарим үйл ажиллагаа хууль тогтоомжтой нийцээгүй, батлагдсан орон тоог хэтрүүлэн ажиллаж ирсэн байна**Компанийн бүтэц, орон тоо, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хяналгүй баталсан байна**

1.1 “МИАТ” ТӨХК нь /Цаашид компани гэх / 2017 оны байдлаар бүтцийн хувьд Гүйцэтгэх захирал, тэргүүн болон дэд захирлууд, 1 алба, 19 хэлтэс, 3 тасаг, 6 төлөөлөгчийн газар, харьяа 1 авто баазтай байна. /Компанийн бүтцийг хавсралт 1-ээс харна уу./

1.2 Компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөг 3 жилийн хугацаатай боловсруулж түүнд тулгуурлан төлөвлөлтийн хэлтсээс тухайн оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгод түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг бэлдэн ТУЗ-өөр хэлэлцүүлж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын /ТӨБЗГ/ тогтоолоор батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

1.3 Өнгөрсөн жилүүдэд гадаадын байгууллагаас компанийн үйл ажиллагааг шинэчлэх бизнес төлөвлөгөөг боловсруулж өгсөн бөгөөд агаарын тээврийн зах зээлийн Монгол Улсын бодит нөхцөлүүдийг төдийлөн харгалзаж үзэлгүй хэт өндөр ашгийг богино хугацаанд нэмэгдүүлэх, эсхүл компанийн цар хүрээг өргөжүүлэх бус үйл ажиллагааг багасгах буюу алдагдалтай нислэгүүдийг /Берлин, Осака/ зогсоох, нийт ажилтнуудыг 20 хувиар багасгах гэх мэт зөвлөмжүүдийг өгсөн нь 2012-2017 онуудад хэрэгжээгүй байна.

1.4 Энэ нь Монгол Улсын эдийн засгийн өсөлт, уналт, инфляцын түвшин, валютын ханшны нөлөөлөл, дотоод болон гадаад хүчин зүйл зэргийг урьдчилж тооцоогүйтэй холбоотой байна. Иймд төлөвлөгөөг гадны компаниудаар хийлгүүлснээс, Монгол орны онцлог нөхцөл байдалтай нийцүүлэн компани өөрийн нөөц бололцоонд тулгуурлан боловсруулах талаар судлан үзэх нь зүйтэй байна.

1.5 Нөгөө талаар дээрх төлөвлөгөөнд агаарын тээврийн үйл ажиллагаанд шинээр нэвтэрч буй технологи, удирдлага зохион байгуулалт болон коммерийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр өгсөн боломжтой зөвлөмжүүдийг дараа дараагийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнүүдэд тусган хэрэгжүүлж байна.

1.6 ТӨБЗГ болон ТУЗ-өөс компанийн эдийн засгийн үзүүлэлтийн талаарх тоо мэдээлэл, судалгаа, үр ашгийн үндэслэлийг нарийвчлан хянан үзээгүй, нислэг үйлдвэрлэлийн хэмжээтэй уялдсан бодит орон тоог батлан өгдөггүй нь Гүйцэтгэх захирлын тушаалаар орон тоо жил бүр нэмэгдэж, хүний нөөцийн тооцоо судалгаа бүрхэгдэх, боловсон хүчний бодлого алдагдаж түүнийг эргэн хянахад хүндрэл учрах, халаа сэлгээ үргэлжлэх нөхцөл байдлыг үүсгэж байна.

1.7 Тухайлбал тус компанийн нийт орон тоог ТУЗ-өөс дэмжсэн болон ТӨБЗГ-ын 2017 оны 23 дугаар тогтоолоор 675-аар батлан өгсөн байхад оны эцэст 879 /жилийн эцсийн цалингийн цэсээр/ буюу 204 орон тоо илүү ажиллуулсан байна.

1.8 ТӨБЗГ-ын тогтоолоор баталсан 675 орон тоон дээр бизнесийн үйл ажиллагааны өсөлт буюу зуны нислэгийн ачаалал ихсэх үед нислэг үйлдвэрлэлийн хэмжээтэй уялдан түр хугацаатай 80 ажилтан, мөн аж ахуйн тооцооны зарчмаар гэрээний дагуу хөлсөөр ажиллуулж байгаа цэвэрлэгээ үйлчилгээний 60 ажилтан нэмэгддэг байна.

Эдгээр 140 ажилтныг нийт ажиллагсдын тоонд оруулалгүй зөвхөн цалингийн хэмжээгээр нь төлөвлөгөөнд нэмэгдүүлж тусган батлуулдаг бөгөөд үүнээс гадна 64 /Бүхээгийн болон газрын үйлчилгээний/ ажилтны ажлын хөлсөөр цалингийн зардал хэтэрсэн байна.

1.9 Гэтэл Захиргаа хүний нөөцийн хэлтсээс гаргасан судалгаагаар 2017 оны эцэст нийт орон тоо бодитойгоор 906 байна. Үүнээс 27 орчим хүнийг цалин авдаггүй, орон тоо нь хадгалагдан үлдсэн талаар тайлбарлаж байна.

1.10 Компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар 2016 онд нийт 66 хүн халагдаж, 83 хүн томилогдсон, 2017 онд нийт 50 хүн халагдаж, 102 хүн томилогдсон байна.

1.11 Зуны нислэгийн үеэр түр ажиллуулсан ажилчдыг чөлөөлдөг байсан боловч сүүлийн жилүүдэд нислэг тээвэрлэлтийн үйл ажиллагаа өвлийн улиралд ч гэсэн нэмэгдсэн учир



үргэлжлүүлэн ажиллуулах, орон тоог нэмэгдүүлэх саналыг жил бүр ТУЗ болон ТӨБЗГ-т оруулдаг боловч бодитой эсэхийг хянан үзэх, баталгаажуулах ажил хийгдэхгүй байна.

1.12 Тус компани сонгон шалгаруулалтын арга хэлбэрийг ашиглан агаарын тээврийн салбарын өндөр ур чадвартай, нарийн мэргэшсэн ажилтнуудаар хүний нөөцөө бүрдүүлэх, ажилтан бүрийн мэргэжил, ажлын бүтээмж, хариуцлага, ур чадварыг харгалзан үзэж чадварлаг баг бүрдүүлснээр хөдөлмөрийн бүтээмжийг тодорхой хувиар нэмэгдүүлэх, цалин хөлс урамшууллын илүү үр өгөөж бүхий тогтолцоог нэвтрүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авах шаардлагатай болжээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрдүүлэх, гүйцэтгэх удирдлагыг томилоход холбогдох хууль тогтоомжийг баримтлаагүй байна

1.13 Төрийн өмчийн хорооны 2012 оны 300 дугаар тогтоолоор баталсан Компанийн дүрмийн 5-д “Компанийн удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага байна”, 7.1-д “Компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгож, чөлөөлнө” гэж заасан байна.

ТУЗ-ийн даргаар Д.Даваасүрэн /ГХЯ-ны ТНБД/, гишүүдээр С.Мөнхнасан /ЗТЯ/, Ц.Түвшинзаяа /ТӨБЗГ/, Д.Ганболд /ЗГХЭГ/, Н.Нарангэрэл /СЯ/, Р.Мэргэн /ЗТЯ/, хараат бус гишүүнээр Б.Хангай /ОУНБ/, О.Банзрагч /Улаанбаатар банкны захирал/ нар ажиллаж байна. ТУЗ-ийн гишүүдийг ТӨХ-ны болон Зам, тээврийн салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор чөлөөлж ирсэн байна.

1.14 Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг удирдлага болгон 2017 онд нийт 6 удаагийн ээлжит хурлыг зохион байгуулж, ТӨБЗГ-аас удирдамж авч 20 гаруй асуудлаар холбогдох шийдвэр 13 тогтоол, 8 тэмдэглэлийг гарган ажиллажээ.

1.15 ТУЗ-ийн дарга шинээр сонгогдоогүй үед ТУЗ-ийн хуралдааныг зохион байгуулж Гүйцэтгэх удирдлагыг томилох, чөлөөлөх асуудлыг шийдвэрлэхдээ ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 3.5¹, Компанийн дүрмийн 7.7², 8.6³, 8.6.1⁴-д заасан гүйцэтгэх захиралд тавигдах шалгуур “Менежментийн ур чадвартай, иргэний агаарын тээврийн чиглэлээр удирдах албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан байх” гэснийг тус тус зөрчсөн байна.

1.16 Төрийн өмчийн хорооны тогтоолоор ТУЗ-ийн даргыг сонгох, Гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх саналыг ТУЗ-д гаргадаг боловч эсрэг санал гардаггүй, гишүүд 100 хувийн саналаар байнга дэмжиж шийдэж байгаа нь ТБОНӨТХ-ийн 21.6⁵ дахь заалтаас шалтгаалж ТУЗ-ийн гишүүдийн сонгох эрхийг хязгаарлаж, зөвхөн ТӨБЗГ-ын удирдамжийг биелүүлдэг ажил болон хэвшжээ.

1.17 ТУЗ-ийн дарга Д.Даваасүрэнг /ГХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга/ ТӨБЗГ-ын 2016 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 80 дугаар тогтоолоор ТУЗ-ийн гишүүнээр сонгож мөн газрын 1/350 дугаар удирдамжаар ТУЗ-ийн даргыг сонгож батлуулах санал ирүүлж, ТУЗ-ийн 01/16 дугаар тогтоолоор баталсан байна.

1.18 Энэ нь Компанийн тухай хуулийн 78.1⁶ дэх заалтыг зөрчиж ТУЗ-ийн нийт гишүүдийн 67 хувийн ирцтэйгээр түүнийг сонгон батлах асуудлыг хэлэлцсэн бөгөөд бусад гишүүд албан

¹ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 3.5 ТУЗ-ийн хурлаар ТУЗ-ийн даргын баталж, урьдчилан холбогдох материал тараасан асуудлыг хэлэлцэнэ.

²ТУЗ-өөс гаргасан тэмдэглэл, тогтоол нь ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж, компанийн тэмдгийг дарснаар хүчин төгөлдөр болно.

³Гүйцэтгэх захирал нь дараах шалгуурыг хангасан байна.

⁴Менежментийн ур чадвартай, иргэний агаарын тээврийн чиглэлээр удирдах албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан байх.

⁵ТБОНӨТХуулийн 21.6 Төрийн өмчийн төлөөлөгч болон төлөөлөн удирдах зөвлөлийн төрийг төлөөлөх гишүүнээр томилогдсон этгээд нь төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчээс баталсан удирдамж, зааврыг баримтлан ажиллана. Удирдамж, зааврыг зөрчсөн буюу зохих ёсоор биелүүлээгүй нь түүнийг томилсон шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно.

⁶ 78.1 ...төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүний олонхийн саналаар сонгоно.



ажилтай тул хуралд оролцоогүй гэсэн нь баримтаар нотлогдохгүй, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 3.17⁷, 3.19⁸, 4.4⁹ дэх заалтуудтай зөрчилдөж байна.

⁷ 3.17 Гишүүд хуралд биеэр оролцох үүрэгтэй.

⁸3.19 Хуралд биеэр хүрэлцэн ирэх боломжгүй гишүүн бичгээр санал өгөх.

⁹4.4 Гишүүдийн бичгээр гаргасан саналыг тэмдэглэлд хавсаргана.


Бүлэг 2. Компанийн зарим хөрөнгө нөөц, үйл ажиллагааны зардлыг хэмнэлттэй зарцуулаагүй, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна

Компанийн ашгийн хэмжээ 2017 онд өмнөх оноос нэмэгдсэн ба орлогын дийлэнх хувийг зорчигч тээврийн орлогоос бүрдүүлсэн байна

2.1 Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын 2016-2017 оны төлөвлөгөөг ТӨХ-ны 2015 оны 819, ТӨБЗГ-ын 2017 оны 23 дугаар тогтоолуудаар тус тус баталсан байна.

2.2 Компани 2016 онд 295.8 тэрбум төгрөгийн орлого, 289.0 тэрбум төгрөгийн зардал, татварын дараах алдагдал 1.2 тэрбум төгрөг, 2017 онд 393.8 тэрбум төгрөгийн орлого, 333.9 тэрбум төгрөгийн зардал, 48.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Компанийн санхүүгийн үндсэн үзүүлэлтийг графикаар үзүүлбэл,



Компанийн ашгийн хэмжээнд ам.доллартай харьцах төгрөгийн ханшийн хэлбэлзэл нөлөөлж ирсэн бөгөөд 2016 онд ханш 494.0 төгрөгөөр суларснаас шалтгаалж 39.8 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн бол, 2017 онд ханш оны эхнээс 62.4 төгрөгөөр чангарснаар 6.1 тэрбум төгрөгийн ашиг олжээ.

2.3 Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2017 онд орлого 33.1 хувиар, зардал 15.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1.

“МИАТ” ТӨХК -ийн санхүүгийн үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2016 он		2017 он		Төл/Гүйц				/ тэрбум төгрөг/ 2017/2016	
	Төл	Гүйц	Төл	Гүйц	2016 он		2017 он		Дүн	Хувь
					Дүн	Хувь	Дүн	Хувь		
Нийт орлого	251.2	295.8	319.6	393.8	44.7	117.8	74.2	123.2	98.0	133.1
Үндсэн ү.а-ны орлого	233.2	267.6	299.7	364.2	34.4	114.8	64.5	121.5	96.6	136.1
Үндсэн бус ү.а-ны орлого	17.8	26.2	19.5	25.1	8.5	147.6	5.7	129.2	(1.1)	95.9
Ү.а-ны бус орлого	0.2	2.0	0.4	4.5	1.8	844.2	4.0	1,020.1	2.5	221.5
Нийт зардал	251.1	289.0	303.7	333.9	(37.9)	115.1	(30.2)	109.9	44.9	115.5
Шууд зардал	169.5	175.3	218.0	239.0	(5.8)	103.4	(21.0)	109.6	63.6	136.3
Шууд бус зардал	38.2	43.1	44.8	55.4	(4.9)	113.0	(10.6)	123.6	12.3	128.6
Ерөнхий ба удирдлагын зардал	22.8	27.2	27.5	33.7	(4.5)	119.6	(6.2)	122.6	6.5	123.7
Ханшийн зөрүүний алдагдал	20.6	39.8	13.4	(6.0)	(19.2)	193.0	19.4	(44.8)	(45.8)	(15.1)
Ү.а-ны бус зардал	-	3.6	-	11.8	(3.6)		(11.8)		8.3	332.3
Татварын өмнөх ашиг	0.1	6.8	15.9	59.9	6.7	10,275	44.0	377.0	53.1	882.2
Орлогын албан татвар	0.0	7.1	1.6	11.7	7.1	107,557	10.2	738.9	4.6	165.2
Цэвэр ашиг	0.1	(0.3)	14.3	48.2	(0.4)	(533.6)	33.9	336.8	48.5	(15,178)

2.4 Компани орлогыг төлөвлөхдөө урьд жилүүдийн гүйцэтгэлд тулгуурлан, гадаад дотоод орчны нөлөөлөл, зах зээлийн нөхцөл байдал, суудал ашиглалт, давтамж, шинэ чиглэл, чиглэл хамтран эзэмших хэлэлцээр, хуваарьт болон захиалгат нислэгийн тоо, валютын ханшийн



өөрчлөлт зэргийг харгалзан тооцдог байна. /Орлогын бүрэлдэхүүнийг хавсралт 2-оос харна уу./

2.5 Компанийн 2017 оны нийт орлого 293.1 тэрбум төгрөгийн буюу 74.4 хувийг зорчигч тээвэрлэлтээс, 33.7 тэрбум төгрөг буюу 8.6 хувийг захиалгат нислэгээс, 18.9 тэрбум төгрөг буюу 4.8 хувийг нойтон түрээсийн үйл ажиллагаанаас, 17.7 тэрбум төгрөг буюу 4.5 хувийг ачаа тээвэрлэлтээс, 30.5 тэрбум төгрөг буюу 7.7 хувийг бусад үйл ажиллагаанаас олжээ.

2017 онд үндсэн үйл ажиллагааны орлого өнгөрсөн онтой харьцуулахад 36.0 хувиар буюу 96.6 тэрбум төгрөгөөр өссөн нь зорчигч тээвэрлэлт, захиалгат нислэг, нойтон түрээсийн орлогын өсөлтөөс голчлон шалтгаалснаас гадна, гадаад болон дотоодын захиалгат нислэгээр нийт 33.7 тэрбум төгрөгийн орлого олсон нь нөлөөлсөн байна.

Компани нь орлого нэмэгдүүлэх, онгоцны сул зогсолт гаргахгүйн тулд нойтон түрээсийн үйлчилгээг үзүүлж байна

2.6 Компани нойтон түрээс (онгоцыг нисэх бүрэлдэхүүнтэй хамт түрээслэх)-ийн үйлчилгээг авахын тулд “ZELA Aviation” компанитай “Худалдааны ерөнхий зуучлалын” гэрээг 2015 оны 10 дугаар сард байгуулжээ.

Гэрээнд нойтон түрээсийн тохиолдол бүрт талуудын харилцан тохиролцсоны дагуу тогтоосон тарифаар блок цаг тутам (онгоц хоолойноос гараад буцаад хоолойд зогсох хоорондох цагуудыг хэлнэ) 200.0 ам.доллар, сар бүр тогтмол маркетингийн болон зөвлөхийн зардалд 4.000 евро төлдөг ба 2016-2017 онуудад нийт 1.1 сая ам.доллар, 231.0 мянган евро төлсөн байна.

Нойтон түрээсийн үйлчилгээнд 17 жилийн насжилттай “B767-300 ER” EI-FGN бүртгэлийн дугаартай хөлөг, 18 жилийн насжилттай “B737-800” EI-CSG бүртгэлийн дугаартай агаарын хөлгүүдийг ашиглаж байгаа ба 2016-2017 онд нийт 5 удаа нойтон түрээсийн үйлчилгээг бусад улс оронд үзүүлжээ.

Агаарын хөлгийн нойтон түрээсийн гэрээнд заасан нислэгийн хугацаа, блок цаг, төлбөрийн хэмжээний мэдээллийг харуулав.

Хүснэгт-2

/мянган ам.доллар/

№	Гэрээний дугаар	Нислэг үйлдэх хугацаа		Хамтрагч байгууллага	Блок цаг	Блок цаг/үнэ	Илүү цаг
		Эхлэх	дуусах				
1	16/291	2016.09.15	2016.10.17	“Biman Bangladesh Airlines”	300	5.200	5.000
2	16/032	2016.04.15	2016.10.15	“Travel Service A.S”	2000	2.350	1.950
3	17/020	2017.01.15	2017.02.20	“Mega Global Air Services”	280	4.000	Тохирох
4	17/429	2017.11.29	2017.12.31	“Sunrise Airways”	270	4.450	Тохирох
5	17/022	2017.04.05	2017.10.15	“Travel Service A.S”	2100	2.350	1.950

2.7 Бүгд найрамдах Гайти улсын “Sunrise Airways” компанитай нийт 270 блок цагийн нислэгийг 1 сарын хугацаанд үйлдэх гэрээ байгуулан ажиллаж уг үйлчилгээг үзүүлснээр дараах орлогыг олсон байна.

Хүснэгт-3, B767-FGN агаарын хөлгийн нойтон түрээсийн зардлын үзүүлэлтийг харуулбал,

1	Нийт орлого /сая.төг/	4.082
2	Нийт Зардал	3.131
2.1	Агаарын хөлгийн түрээсийн зардал	702
2.2	Засвар үйлчилгээ нөөц	585
2.3	Техник үйлчилгээний зардал	196
2.4	Аэронавигаци, буулт хөөрөлтийн хураамж	9
2.5	Даатгалын зардал	72
2.6	Нисэх бүрэлдэхүүний томилолтын зардал	279
2.7	Цалингийн зардал	593
2.8	Зуучлалын хөлс	649
2.9	Ерөнхий томилолтын зардал	21
2.10	Нислэгийн зөвшөөрөл	25
3	Ашиг	951

Дээрх хүснэгтээс харахад 1 сарын нойтон түрээсийн үйлчилгээг үзүүлснээр нийт 4.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлснээс 3.1 тэрбум төгрөгийн зардал гарч 951.0 сая төгрөгийн ашиг олсон байна.

Агаарын хөлөг тус бүрийн орлого, зарлага, ашгийг харуулбал,

Хүснэгт-4

/сая төгрөг/


Үзүүлэлт	Нойтон түрээсийн гэрээ /он, дугаар/						Нийт дүн
	16/291	16/032	Дүн	17/429	17/022	Дүн	
Нийт орлого	3,609	10,590	14,199	4,082	10,988	15,070	29,269
Нийт зарлага	1,763	8,067	9,830	3,131	9,203	12,334	22,164
Ашиг	1,846	2,523	4,369	0,951	1,785	1,785	7,105

2.8 Нойтон түрээсийн үйлчилгээг үзүүлснээр 2016 онд 14.2 тэрбум, 2017 онд 15.0 тэрбум төгрөг буюу нийт 29.2 тэрбум төгрөгийн орлого олж, 22.1 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 6.1 тэрбум төгрөгийн ашиг олсон байна.

“Mega Global Air Services” компани нь нойтон түрээсийн үйлчилгээний төлбөрөө бүрэн төлөөгүйгээс авлага үүссэн байна

2.9 Компани 2017 оны 1 дүгээр сарын 15-наас 2 дугаар сарын 20-ны хооронд Бүгд Найрамдах Малдив Улсын “Mega Global Air Services” компанитай байгуулсан гэрээний дагуу байршуулалтын нислэгийн (тухайн улсад зорчигчгүйгээр агаарын хөлгийг хүргэх) 41.6 блок цаг мөн зорчигч зөөх нислэг 280 блок цагийн нойтон түрээсийн үйлчилгээ үзүүлжээ. Үйлчилгээний хөлсийг нислэгийн блок цагийн 4000 ам.доллар, байршуулалтын нислэг нэг блок цаг нь 3200 ам.доллар, бусад нэмэгдэх зардлыг суулгаснаар нийт төлөгдөх дүн 1.2 сая ам.доллар төлөх байснаас нислэг үйлдэх нэг сарын хугацаанд үйлчилгээний төлбөрт нийт 612.3 мянган ам.доллар төлөөд байна.

/Төлбөрийн гүйцэтгэлийг графикаар харуулбал,/



2.10 Дээрх төлбөрөөс нойтон түрээсийн зуучлалын хөлсөнд “Zela Aviation” компанид 54.1 мянган ам.долларыг төлсөн.

“Mega Global Air Services” компани нь 2017 оны байдлаар гэрээний дагуу үлдэгдэл төлбөр болох /алдангийн хамт/ 706.7 мянган ам.долларыг санхүүгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалж төлөх боломжгүй байдал үүсэж улмаар 2017 оны 2 дугаар сарын 28-нд сайн дураараа татан буугдах тухай зарласан ба одоогоор компанийн өмч хөрөнгийг борлуулж олсон орлогоор өр төлбөрөө барагдуулах ажил хийгдэж байна.

2.11 Компани 2016 онд нийт агаарын ачааны 59 хувийг тээвэрлэж байсан бол 2017 онд 61 хувийг тээвэрлэж зах зээлд эзлэх хувь нэмэгдсэн, Азийн чиглэлийн ачаа тээвэр 2-10 хувь, Европ чиглэлийн ачаа тээвэр 5 хувь тус тус өссөн байна.

Хүснэгт-5

Ачаа тээвэрлэлтийн үзүүлэлтийг харуулбал,

Чиглэл	Тээвэрлэгчийн нэр	2016 он		2017 он		Өсөлт/бууралт 2016 – 2017 он
		Ачаа /тонн/	Зах зээлд эзлэх хувь	Ачаа /тонн/	Зах зээлд эзлэх хувь	
Бээжин	МИАТ	175	28	224	38	49
	Эйр Чайна	460	72	363	62	-97
Сөүл	МИАТ	1582	59	1779	61	197
	Корэйн Эйр	1080	41	1161	39	81
Европ	МИАТ	371	56	317	49	- 54

	Аэрофлот	110	17	150	23	40
	Туркиш	183	28	183	28	0
Токио	МИАТ	292	100	303	100	11
Хонг.К	МИАТ	211	100	251	100	40
Нийт	Бусад	1832	41	1857	39	25
	МИАТ	2630	59	2874	61	244

2.12 Компани 2017 онд нийт 2006 удаагийн аяллаар 610.3 мянган зорчигч тээвэрлэсэн байна.

Нислэг, тээвэрлэлтийн үзүүлэлтүүдийг харуулбал,

Хүснэгт-6

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2016 оны гүйц	2017 он		Өөрчлөлт		Харьцуулалт	
				Төл	Гүйц	тоо	хувь	2017/2016	
								тоо	хувь
1	Аяллын тоо /нислэг/	тоо	1667	2043	2006	(37)	98.2	339	120.3
2	Зорчигч тээвэрлэлт	хүн	492046	585855	610391	24536	104.2	118345	124.1
3	Ачаа тээвэрлэлт	тонн	2903	3010	2970	(40)	98.7	67	102.3
4	Суудал ашиглалт	хувь	74.5	74.8	78.1	0.03	104.4	0.0	104.8
5	Даац ашиглалт	хувь	56.6	59.2	59.3	0.1	100.1	0.0	104.7

2.13 Нислэг тээвэрлэлтийн төлөвлөгөө 98.2 хувь биелж өмнөх оны мөн үеэс 20.3 хувиар өссөн байна. Энэ нь БНСУ, Япон, БНХАУ-д зорчих зорчигчдын тоо нэмэгдсэнээр зорчигч тээвэрлэлт 4.2 хувиар, өмнөх оны мөн үеэс 24.1 хувиар өсч, /2017 онд БНСУ, БНХАУ-ын хоорондын харилцаа таагүй байдлаас шалтгаалж зорчигчид Монгол Улсаар дамжин нисэх урсгал нөлөөлсөн, зуны улиралд БНСУ-ыг зорих зорчигчдын урсгал нэмэгдсэнтэй холбоотой/ суудал ашиглалт 6-8 саруудад 80-84 хувь, бусад саруудад 65-80 хувьтай байна.

2.14 Компанийн зорчигч тээвэрлэлт нэмэгдсэн, шинээр чиглэл нээгдсэнтэй холбоотой үнэ тарифын уян хатан бодлогыг нэвтрүүлэх ажлын хүрээнд ахмад настны, гэр бүлийн, окутан залуусын, хамт олны зэрэг олон төрлийн урамшуулалтай тарифуудыг зах зээлд шинээр нэвтрүүлсэн байна. Зорчигчийн билетийн үндсэн тариф нь Ази тив рүү харьцангуй хямд, Европ руу өндөр байгаа нь манай улсын валютын ханшийн хэлбэлзэлтэй шууд холбоотой байна.

Гадаадын авиа компаниудыг агаарын тээврийн зах зээлд оруулснаар нислэгийн зарим чиглэлд алдагдал хүлээжээ

2.15 “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын баримт бичиг”-ийн 3.8 дахь хэсэгт “Улаанбаатар-Сөүл-Улаанбаатарын чиглэлд хоёрдогч тээвэрлэгчийг оруулахгүй”, мөн баримт бичгийн 3.9 дэх хэсэгт “Гадаад улсын үндсэн нислэгийн чиглэлээс Монгол Улс руу хуваарьт нислэг үйлдэх тээвэрлэгчийн тухайд “нэг шугам-нэг тээвэрлэгч” бодлого баримталж, үндэсний тээвэрлэгч компанийн өрсөлдөх чадварыг сайжруулж, ижил тэнцүү орчинд өрсөлдөх боломжийг бүрдүүлнэ” гэж тус тус заасан байна.

Дээрх бодлогын баримт бичиг бүрэн хэрэгжээгүйгээс манай улсын агаарын тээврийн зах зээлд олон улсын томоохон сүлжээ авиа компаниуд орж ирснээр үндэсний тээвэрлэгч компанийн ашиг орлогод сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал,

- 2014 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн Монгол-БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд 2016 оны 6 дугаар сарын 26-наас эхлэн “Эйр Бусан” компани дангаараа 162 суудалтай А320-200 агаарын хөлгөөр Бусан-УБ шинэ чиглэл нээн үйлчилгээ үзүүлж эхэлжээ. Компанийн зүгээс УБ-Сөүл-Бусан чиглэлийн зах зээлээ алдахгүйн тулд 2017 оны 6 дугаар сарын 22-ноос эхлэн Бусан хот руу шинэ чиглэл нээн 7 хоногт 2 давтамжаар В737-700 агаарын хөлгөөр нислэг үйлдсэн боловч 3.1 тэрбум төгрөгийн орлого алдсан байна.

УБ-Сөүл-Бусан чиглэлийн зах зээлд эзлэх хувийг харуулбал,

Хүснэгт-7

№	Нислэгийн компани	Нислэгийн чиглэл	Эхэлсэн огноо	УБ-СӨҮЛ-БУСАН чиглэлийн зах зээлийн харьцаа /хувиар/	
				Өмнөх онууд	2017 оны байдлаар
1	“МИАТ” ТӨХК	УБ-Сөүл хот	1994	48	44
2	“Korean air”	УБ-Сөүл хот	1999	52	50
3	“Air Busan”	УБ-Бусан хот	2016	-	6



- УБ-Москва-Берлиний байнгын чиглэлийг Монгол Улс Европ руу гарах үндсэн гарц гэж тодорхойлж, жуулчлалын улирлаар Улаанбаатар-Франкфуртын нэмэлт чиглэлийг гаргадаг боловч алдагдал хүлээсээр байна.
- Европын чиглэлд сүүлийн 5 жилд 120.0-128.0 мянган зорчигч тогтвортой зорчиж байсан ба 2012 оноос “Туркиш Эйрлайнс” компани Истанбул–Улаанбаатар чиглэлд 7 хоногт 2 удаагийн давтамжтай нислэг үйлдэх болсноор зах зээлийг тэлэх бус харин Европ чиглэлийн зорчигчдын урсгалыг өөртөө татаж, Европын зах зээлийн 30-32 хувийг эзлэснээр “МИАТ” компани 2017 оны байдлаар 26.2 тэрбум төгрөгийн орлого олох боломжоо алдсан байна. Цаашид “Туркиш Эйрлайнс” компани 7 хоногийн давтамжаа нэмбэл тус компанийн Европын чиглэлд эрсдэл үүсэхээр байна.

Шинээр чиглэл нээж ашигтай ажиллах хүртэл тодорхой хугацаа зарцуулдаг байна

2.16 2016-2017 онд тус компаниас бодлогын хүрээнд шинээр чиглэл нээх судалгаа хийж олон улсын 2 чиглэлд /УБ-Бусан-УБ, УБ-Бангкок-УБ/ нислэг эхэлсэн боловч одоогоор алдагдалтай ажиллаж байна. Үүнд,

- УБ-Бусан чиглэлд 2017 онд орлогыг 7.1 тэрбум төгрөг, зардлыг 8.2 тэрбум төгрөг, алдагдлыг 1.1 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн боловч 3.1 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан,
- УБ-Бангкок чиглэлд Хонконгийн Катар Песипик Эйрлайн компанитай код хуваах нислэг үйлдэн орлогыг 1.8 тэрбум төгрөг, зардлыг 3.3 тэрбум төгрөг, алдагдал 1.5 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр орлого 2.8 тэрбум, зардал 3.7 тэрбум, 0.9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Шинээр эхэлсэн олон улсын нислэгүүд нийт 4.0 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан боловч олон улсын агаарын тээврийн жишгээр шинэ чиглэлийг бойжуулах хугацаа нь 3-5 жил байдаг байна.

Шатахуун нийлүүлэх бусад компаниудад өрсөлдөх боломж олдохгүй байх нөхцөл үүсчээ

2.17 Агаарын хөлгийн шатахуунд 2017 онд нийт 67.3 тэрбум төгрөг зарцуулсан нь өнгөрсөн оноос 23.4 тэрбум төгрөгөөр их, төлөвлөснөөс 6.5 тэрбум төгрөгөөр бага байна. Энэ нь шатахууны үнийн өсөлт төлөвлөсөн хэмжээнд өсөөгүй, тогтвортой байсан, валютын ханшийн бууралтаас шалтгаалж зардал хэмнэгдсэн байна.

Компанийн нийт зардлын 20 хувийг агаарын хөлгийн шатахуун эзэлдэг бөгөөд дотоодоос нийлүүлж буй шатахууны үнэ гадаад орнуудаас авч байгаа үнээс 23.2 хувиар өндөр байна.

Шатахууны үнийн үзүүлэлтийг харуулбал,

Хүснэгт-8

Үзүүлэлт	Нийт сумласан хэмжээ, /мян.тонн/		1 тонн дундаж үнэ /ам.доллар/	
	2016 он	2017 он	2016 он	2017 он
Монгол улсаас	9.3	12.3	775	727
Гадаад орноос	27.4	30.0	495	590
Нийт/дундаж	36.7	42.3	635	658

Энэ нь дотоодын шатахууны үнэ нь гадаад зах зээлээс тонн тутамд 100-200 ам доллараар өндөр байгаа нь валютын ханшийн өсөлт, хилийн үнийн өөрчлөлт, шатахуун нийлүүлэгч орны эдийн засаг, улс төрийн бодлоготой шууд холбоотой байна.

2.18 Дотоодоос худалдан авсан шатахууны үнийн хувьд 2016 оны 11 дүгээр сараас 2017 оны 11 дүгээр сар хүртэлх хугацаанд валютын ханш 18.5 хувиар, хил дээрх нэгж үнэ 54.5 хувиар өссөн нь гэрээний үнийн дүнгээс 11.0 тэрбум төгрөгөөр хэтрэхэд нөлөөлсөн. /Худалдан авалтыг хавсралт 3-аас харна уу./

2.19 Агаарын хөлгийн шатахууны дотоод зах зээлийн худалдан авалтыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулсан боловч тендерт ялагч “Сод Монгол Групп” ХХК, “Мэргэван” компаниудын хувьд техник, тоног төхөөрөмжийн нөөц, газар зүйн байрлал, удаан жилийн гадаад түншийн харилцаа сайтай зэрэг давуу байдал /нисэхийн районд өөрийн шатахуун хадгалах сав, танкыг байрлуулсан, гаднаас хямд үнийн эх үүсвэртэй г.м./ нь шинээр өрсөлдөх компаниудын боломжийг хязгаарлаж байна.



Зарим шууд болон шууд бус зардлууд төлөвлөснөөс өссөн байна

2.20 Нислэгийн үйл ажиллагаа өргөжсөнөөр зардал өнгөрсөн оноос 44.9 тэрбум төгрөгөөр, төлөвлөгөөнөөс 30.2 тэрбум төгрөгөөр хэтэрсэн байна.

2.21 Шууд зардалд агаарын хөлгийн түрээсийн төлбөр 36.3 тэрбум төгрөг буюу 15.2 хувь эзэлдэг бөгөөд тайлант онд 3.2 тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь 2017 онд шинээр түрээслэсэн агаарын хөлгийн (Боинг 737-700) түрээсийн төлбөрт 2.9 тэрбум төгрөг бүртгэсэн нь нөлөөлсөн байна. /Шууд зардлын дэлгэрэнгүйг хавсралт 4-өөс харна уу./

2.22 Агаарын хөлгийн техникийн үйлчилгээний зардал 11.8 тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь шинээр авсан түрээсийн онгоцны зардал төлөвлөгөөнд тусгагдаагүй, нислэгийн цаг нэмэгдсэн, засвар үйлчилгээний нөөцийн зардал өссөнтэй холбоотой байна.

- Инженер техникийн болон газрын үйлчилгээний ажилтнуудын цалингийн зардал өнгөрсөн оны мөн үеэс 17 хувь, төлөвлөгөөнөөс 26 хувь өссөн нь орон тооны өсөлт, үр дүнгийн урамшуулалт цалинг төлөвлөлтөд тусгаагүй,
- Тайлант онд зорчигчийн тоо 24 хувиар, зорчигч тээвэрлэлтийн орлого 34 хувиар өссөн зэргээс шалтгаалж борлуулагч агентын шимтгэлийн зардал 52 хувиар, СИТА буюу суудал захиалгын зардал 59 хувиар нэмэгдсэн,
- Гуравдагч этгээдэд үзүүлсэн агаарын хөлгийн техник үйлчилгээний орлого өссөн нь түүнтэй холбоотой засварын зардал өсөхөд нөлөөлсөн байна. Мөн шинээр нээсэн Бусан чиглэл, Бангкок чиглэл, бусад үйл ажиллагааг идэвхжүүлэхтэй холбоотойгоор зар сурталчилгааны зардал 300.0 сая төгрөгөөр өссөн байна. /Шууд бус зардлын дэлгэрэнгүйг хавсралт 5-аас харна уу./

2.23 Нисэх бүрэлдэхүүн, инженер техникийн ажилтнуудын болон ерөнхий сургалтад 4.9 тэрбум төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 4.1 тэрбум төгрөгийг зарцуулж, нисэх багийн сургалт, нислэг үйлдвэрлэл зохицуулалт инженерингийн сургалт, дотоод сургалтуудыг Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ИКАО/, ИНЕГ, компанийн холбогдох дүрэм журам, удирдлагын бичиг баримтын хүрээнд “Training & checking manual”, “Нисэхийн сургалтын байгууллагын заавар” түүний сургалтын нэгдсэн хөтөлбөрийн дагуу сургалтуудыг зохион байгуулсан байна.

Сургалтын задаргааг харуулбал,

Хүснэгт-9

/сая төгрөг/

Үзүүлэлт	2016 он					2017 он				
	НБ, ИТА-ны сургалт		Ерөнхий сургалт		Нийт	НБ, ИТА-ны сургалт		Ерөнхий сургалт		Нийт
	Гадаад	Дотоод	Гадаад	Дотоод		Гадаад	Дотоод	Гадаад	Дотоод	
Төлөвлөлт	1,982.0	395.7	612.0	101.7	3,091.4	3,670.5	329.0	705.6	209.2	4,914.3
Гүйцэтгэл	2,417.5	290.5	99.3	9.0	2,816.3	3,358.4	254.2	438.5	85.7	4,136.8

2.24 Ерөнхий удирдлагын зардал 2017 онд өмнөх оны мөн үеэс 6.5 тэрбум төгрөгөөр буюу 23.7 хувь, төлөвлөгөөнөөс 6.2 тэрбум төгрөг буюу 22.6 хувиар өссөн. Үүнд зөвлөх үйлчилгээний зардал 1.7 тэрбум төгрөг (өмгөөллийн зардал, лицензийн төлбөр, удирдлагын кредит картын төлбөр г.м.)-өөр, томилолтын зардал 1.0 тэрбум төгрөг, цалингийн зардал 1.6 тэрбум (урамшуулалт цалин олгосон) төгрөгөөр өссөн нь тус тус нөлөөлжээ. /Ерөнхий удирдлагын зардлын дэлгэрэнгүйг хавсралт 6-гаас харна уу./

Компанийн нийт авлага 8.9 тэрбум төгрөгөөр буюу 18.9 хувиар өсчээ

2.25 Нийт авлагын 78.5 орчим хувь, өглөгийн 80.5 хувь нь тооцоо нийлж баталгаажигдсан ба урт хугацаат авлага нь 2017 онд түрээслэн авсан агаарын хөлгийн барьцаа хөрөнгийг байршуулснаас өсчээ.

Авлагын үзүүлэлтийг харуулбал,

Хүснэгт 10

/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2016 он	Хувь	2017 он	Хувь	Өөрчлөлт	
					Тоогоор	Хувиар
Богино хугацаат авлага	24.3	51.9	27.8	49.3	3.4	14.0
Урт хугацаат авлага	22.5	48.1	28.6	50.7	6.1	26.9
Авлагын дүн	46.8	100.0	56.4	100.0	9.5	20.2

2.26 2008 оноос хойш эзэн холбогдогч нь тодорхойгүй, хөөн хэлэлцэх хугацаа дууссан 1,580.9 сая төгрөгийн найдваргүй авлага байна. НБББББ¹⁰-т авлагын хугацаа 2 жилээс хэтэрсэн авлагын дүнд насжилтаас нь хамааруулж тодорхой хувиар найдваргүй авлагын нөөц байгуулна гэж заасан боловч хэрэгжээгүй байна.

2.27 Компанийн өглөгийн хэмжээ 2017 онд өмнөх оноос нийт 27.0 тэрбум төгрөгөөр буурсан нь зээлийн эргэн төлөлтийг цаг хугацаандаа төлж байсан нь нөлөөлжээ.

Өр төлбөрийг харуулбал,

Хүснэгт-11

/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2016 он	Хувь	2017 он	Хувь	Өөрчлөлт	
					Тоогоор	Хувиар
Богино хугацаат өр	148.9	44.3	183.3	59.4	34.4	23.1
Урт хугацаат өр	187.0	55.7	125.5	40.6	(61.5)	(32.9)
Өглөгийн дүн	335.9	100.0	308.8	100.0	(27.0)	(8.0)

Газрын үнэлгээг өсгөн хөрөнгийг дутуу бүртгэсэн байна

2.28 Улсын Дээд Шүүхийн 2013 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 465 дугаар шүүх хуралдааны тогтоолоор Б.Эрдэнэбилэг /Гүйцэтгэх захирал асан/-ээс 2,764.4 сая төгрөгийг гаргуулан “МИАТ” компанид олгуулах шийдвэр гарсан.

2.29 Хариуцагчаас БЗД-т байрлах 1016 м2 талбайтай 2,139.9 сая төгрөгөөр үнэлэгдсэн агуулахын зориулалттай барилга, 9054 м2 газрын хамт 50 хувиар бууруулсан үнэлгээ болох 1,070.0 сая төгрөгөөр тооцож авахад татгалзах зүйлгүй гэсэн Төрийн өмчийн хорооны 2015 оны 7 дугаар сарын 1-ний 1а/1427 дугаар албан бичиг ирүүлсэн байхад зөвхөн газрыг бүртгэхдээ биет бус хөрөнгө дансанд 1,364.4 сая төгрөгөөр буюу 294.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж агуулахын зориулалттай барилгыг орхигдуулан бүртгэсэн байна.

Хөрөнгө оруулалтын болон худалдан авалтын төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулаагүй байна

2.30 Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан 8,207.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын жагсаалтыг баталсан байна. Мөн компанийн гүйцэтгэх захирлын 2017 оны 2 дугаар сарын 14-ний А/134 дүгээр тушаалаар 55,546.1 сая төгрөгийн (дээрх 8,207.3 сая төгрөг багтсан) худалдан авалтын төлөвлөгөөг баталсан байна.

2.31 Батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний 8,207.3 сая төгрөгийн 66 арга хэмжээнээс 5,031.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 арга хэмжээнд гүйцэтгэлээр 4,475.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын худалдан авалт хийсэн байна. /Хавсралт 7-гоос үзнэ үү./

2.32 2017 онд хэрэгжсэн худалдан авалтад нийт нээлттэй тендерийн 86 арга хэмжээг /tender.gov.mn сайтад/ байршуулахаас 62 арга хэмжээг нэгтгэж, 50 тендерийн урилга байршуулсан. Үүнээс 36 тендерийн үр дүнг мэдээлсэн нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 21.4 “...Захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан вэб хуудсанд байрлуулж, тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ” гэснийг баримтлаагүй байна.

2.33 Нээлттэй тендер шалгаруулалтаар худалдан авах 662.4 сая төгрөгийн 3 арга хэмжээг харьцуулалтын болон шууд худалдан авалтаар, харьцуулалтын арга хэрэглэх 239.6 сая төгрөгийн 7 арга хэмжээг шууд худалдан авахаар төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа ажил үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно” гэж заасныг зөрчсөн байна.

¹⁰Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



2.34 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдах ёсгүй зардал болох мэдээллийн сангийн “Оракл програм”-ын лицензийн төлбөр 245.3 сая төгрөгийн тогтмол зардлыг тусгасан байна.

2017 оны хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 353.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 483.1 сая төгрөгийн бараа материалыг худалдан авсан байна. /Хавсралт 8-аас үзнэ үү./

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчин шууд гэрээ байгуулжээ

2.35 Бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТХуулийн 8.4¹¹-т заасныг зөрчиж тендер зарлахгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна. Үүнд,

- Худалдан авалтын төлөвлөгөөнд 3,495.0 сая төгрөгийн төсөвтэй “Катерингийн үйлчилгээ үзүүлэх” арга хэмжээг тендер зарлахаар тусгасан боловч, “Нүхт түр” ХХК-иар өмнөх гэрээг сунган хэрэгжүүлсээр байна. Тайлант онд 6,811.5 сая төгрөгийн зардал гаргаж, батлагдсан төлөвлөгөөнөөс 3,316.5 сая төгрөгөөр хэтрүүлсэн,
- Тус компани нь харуул хамгаалалтын ажил үйлчилгээг 2011 оноос хойш “Чин хутаг өндөр” ХХК-тай гэрээ байгуулан авч байсан бөгөөд 2017 оны худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдсан нээлттэй тендер шалгаруулалтаар худалдан авах 482.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй харуул хамгаалалтын ажлыг тус компаниар гүйцэтгүүлэхээр шууд гэрээ байгуулсан байна.

Агаарын хөлгийн сэлбэг худалдан авах ажиллагаа нь өөрийн онцлогтой тул хуулийн орчныг сайжруулах шаардлагатай байна

2.36 Компанийн агаарын хөлгийн засвар үйлчилгээний газар анх 1961 онд байгуулагдсан бөгөөд өнөөдрийг хүртэл Монгол улсад ашиглагдаж ирсэн бүх төрлийн агаарын хөлгийн техник үйлчилгээг амжилттай гүйцэтгэж ирсэн ба В737-800 болон В767-300 агаарын хөлгүүдийн шугамын болон хүнд хэлбэрийн техник үйлчилгээг гүйцэтгэхийн зэрэгцээ байгууллагын орлогыг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж эхэлсэн байна.

Тус газар 2014-2017 онуудад хооронд “МИАТ” компанийн В737, В767 маягийн агаарын хөлгүүдэд нийт 14 удаагийн хүнд хэлбэрийн техник үйлчилгээг дотооддоо хийсэн нь компанид тодорхой хэмнэлтийг үзүүлсэн байна.

Гадаадын засварын төвөөр үйлчлүүлэх болон дотооддоо засвар үйлчилгээ үзүүлэх үеийн үр ашиг тооцооллыг харуулбал,

Худалдан авсан сэлбэгийн дүн, засварын тоог харуулбал,

Хүснэгт-12

№	Он	Сэлбэг материалын худалдан авалтын дүн /сая.төг/	Техник үйлчилгээний орлого /сая ам.доллар/	Үйлчилгээ үзүүлсэн агаарын хөлгийн тоо
1	2016	10,497.0	4.06	14
2	2017	17,790.8	4.20	28
3	Нийт	28,287.8	8.26	42

- Засвар үйлчилгээний газар өнөөдрийн байдлаар дотоодын агаарын хөлгийн техник үйлчилгээнээс гадна гадаадын 8 компанитай хамтран ажиллах гэрээ байгуулан агаарын хөлөгт хүнд хэлбэрийн техник үйлчилгээг үзүүлсэн,
- Агаарын хөлгийн техник үйлчилгээ, засварын ажилд шаардагдах сэлбэг материалыг уг онгоцны үйлдвэрлэгч болох Боинг компанийн гаргасан сэлбэгийн жагсаалтад байгаа тусгайлан зааж өгсөн код бүхий үйлдвэрлэгч, нийлүүлэгчээс худалдан авахаар заасан байна.

2.37 Агаарын хөлгийн хөдөлгүүр гэхэд GE-General, хөл анги, тормозны хувьд Honeywell, Messier Bugatti, холбоо навигацйин тоноглол, удирдлагын эд ангийг Rockwell Collins, BAE Systems Control гэх мэт..нийт 140 гаруй үйлдвэр, засварын газар болон нийлүүлэгчтэй харилцан ажилладаг байна.

¹¹Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа ажил үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно



Иймд агаарын хөлгийн сэлбэг нь өндөр үнэтэй, түргэн шуурхай нийлүүлэх шаардлагатай байдаг тул дотооддоо мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд худалдан авах ажиллагааг явуулах боломжгүй болдог ба нислэгийн аюулгүй найдвартай ажиллагааг хангах стандартад нийцсэн сэлбэг, эд ангиудыг баталгаат үйлдвэрлэгч, нийлүүлэгчээс худалдан авдаг тул тус салбарын онцлог байдлыг харгалзан үзэж холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах талаар судлан үзэж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Зарим хөрөнгө оруулалтыг зориулалтын дагуу зарцуулаагүй байна

2.38 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд Хөшигийн хөндийн хөрөнгө оруулалт, лаунжийн зураг төсөв, тоног төхөөрөмжид 300.0 сая төгрөгийн төсөвлөсөн хөрөнгөөс Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн Гүйцэтгэх захирлын 2017 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн А/593 дугаар тушаалаар Чингис Хаан ОУНБ-д лаунж байгуулж 187.1 сая төгрөгийн ажил, үйлчилгээ, тавилга эд хогшлыг худалдан авсан байна. Үүнийг Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ашиглалтад орох үед нүүлгэн шилжүүлэх боломжтой тухай тайлбарлаж байгаа боловч уг ажил үйлчилгээнээс 118.4 сая төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй, тендер зарлалгүйгээр харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан байна.

2.39 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан Хөшигийн хөндийн Бренд хөгжүүлэлтийн арга хэмжээний төсвөөс 100.0 сая төгрөгийг Гүйцэтгэх захирлын 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/453 дугаар тушаалаар дүрэмт болон хөдөлмөр хамгааллын хувцас худалдан авах /багц 4 Агаарын хөлгийн үйлчлэгч нарын дүрэмт хувцас/ тендерт нэмж нийт 200.0 сая төгрөг төлөвлөсөн боловч тухайн ондоо хийгдээгүй байна.

Төлөөлөгчийн газрууд зардлаа батлагдсан төсвөөс 942.3 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна

2.40 Компанийн төлөөлөгчийн газар тухайн орны нисэх буудлуудад хийгдэх газрын үйлчилгээ, шатахууны сумалгаа, хоолны хангалт, зорчигч, ачаа тээш зэрэг нислэгийн хангалт үйлчилгээг тухайн улсын авиа компанитай хамтран ажиллах гэрээний хүрээнд зохицуулж, хяналт тавих зэрэг үүргийг хүлээдэг байна.

Харин төсөвт зардлыг нь компанийн шууд бус зардалд төлөвлөж, гарсан гүйцэтгэлийг шууд бус болон удирдлагын зардалд бүртгэдэг нь зардал, үр дүнг тооцоход хүндрэл учруулж байна.

2.41 2017 онд төлөөлөгчийн газруудын зардалд цалингийн зардал 56%, ажлын байрны түрээсийн зардал 17%, тээврийн зардал 14% эзэлж байгаа бөгөөд батлагдсан төлөвлөгөөнөөс 942.3 сая төгрөгийн хэтрэлттэй, батлагдсан орон тооноос 7 ажилтан илүү /Бээжин 1, Берлин 2, Сөүл 2, Токио 1, Хонконг 1/ ажилласнаар цалингийн зардал хэтэрсэн, урамшуулалт цалин олгосон нь нөлөөлсөн байна. /Төлөөлөгчийн газруудын зардлын тооцоог хавсралт 9-өөс харна уу./

Төлөөлөгчийн газруудаас дараах зөрчил дутагдал илэрчээ

- Токио, Москва дахь төлөөлөгчийн газраас бусад газруудын ажлын байрны түрээсийн зардал, тээврийн зардал хэтэрсэн,
- Токио дахь төлөөлөгчийн газраас бусад газруудын ажлын байрны хангалт үйлчилгээний зардал хэтэрсэн,
- Төлөвлөгөөнд тусгагдаагүй албан томилолтын болон уулзалт хэлэлцээрийн зардлууд гарсан байна.

2.42 Төлөөлөгчийн газрын ажилтнуудын мөрдөх дүрэм журамд зааснаар:

- Компанийн үндсэн зааврын Хавсралт 3.3.2-т “Төлөөлөгчийн газруудын борлуулалт, бусад бүх төлбөрүүд бэлэн болон бэлэн бус мөнгөн хэлбэрээр хийгдэх ба борлуулалтын кредит бичилт хийгдэхгүй, дансаарх авлагагүй байна”,
- Компанийн НБББББичгийн “Мөнгө түүнтэй адилтгах зүйлс” бүлэгт билет борлуулагч нь “Зорчигчийн тийзийн мөнгө болон чекийг хүлээн авч, оффис менежерт мөнгө болон чекийг баримтын хамт тоолж хүлээлгэн өгнө, бэлэн бусаар хийгдсэн тохиолдолд харилцах дансанд мөнгө орсон эсэхийг лавлаж, тийз олгоно.”,



Оффис менежер нь “Зорчигчийн тийзийн мөнгө болон чекийг хүлээн авч, олгосон тийзийн дэс дугаарын дарааллын дагуу “Худалдсан билет, орлогын түүвэр”-т бичих ба нислэг бүрийн орлогын мөнгөн орлогыг өдөрт нь багтаан харилцах дансанд тушаана”, Гадаадын төлөөлөгчийн газрын борлуулалт хариуцсан нягтлан бодогч нь “Төлөөлөгчийн газраас илгээсэн борлуулалтын тайлан, бэлэн мөнгөний болон харилцах дансны тайланг анхан шатны баримттай тулган шалгана, орлогын гүйлгээг орлогын хэсгийн тооцооны нягтлан бодогч нартай тулган баталгаажуулна” гэж заасныг тус тус мөрдөж ажиллаагүй байна. Тухайлбал,

- Төлөөлөгчийн газрын менежер, ажилтнууд нь ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн, тийзийн дэс дугаарын дагуу орлогыг тушаадаггүйгээс хяналт тавих боломжгүй байдалд хүргэсэн,
- Төлөөлөгчийн газруудаас ирүүлсэн тайланд хяналт тавиагүй, тооцоо бодсон актыг баталгаажуулаагүйгээс их хэмжээний авлага үүсэх нөхцөлийг бий болгосон, ерөнхий болон ахлах нягтлан бодогчид нь өөрийн шууд удирдлагад ажиллаж буй ажиллагсдын ажлын гүйцэтгэлд хяналт тавиагүй,
- Бээжин дэх төлөөлөгчийн газрын билет борлуулагч нь 2016 оны 1 дүгээр сарын 1-нээс 2017 оны 8 дугаар сарын 1-ний хооронд бэлнээр борлуулсан тийзийн орлогыг сард 3 удаа оффис менежертээ тушаасан, Москва дахь төлөөлөгчийн газар нь бэлнээр орж ирсэн тийзийн орлогыг 2016 оны 1 дүгээр сарын 1-нээс 2017 оны 6 дугаар сарын 30-ны хоорондох хугацаанд сард нэг удаа дансанд тушааж бүртгэсэн,
- Бээжин дэх төлөөлөгчийн газар бэлнээр тушаасан орлогод баримт үйлдсэн бөгөөд бусад төлөөлөгчийн газруудад баримт үйлдээгүй,
- Тийзийн борлуулалтаас буцаалтыг хассан дүнгээр борлуулалтын орлогоо тайлагнаж ирсэн байна.

Сөүл, Токио, Берлин дэх төлөөлөгчийн газрууд тийзийн орлогыг бүрэн тушаадаггүйгээс 2017 онд өссөн дүнгээр 1.3 тэрбум төгрөгийн авлага үүссэн нь билет борлуулагч болон оффис менежерүүдтэй холбоотой төдийгүй, хууль бус үйлдлийн шинжтэй байж болзошгүй учир хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэлээ.

Бараа солилцооны болон худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүйгээс зардал дутуу илэрхийлэгдсэн байна

2.43 Компанийн хэвлэл мэдээллийн байгууллага болон хамтлаг дуучдын хооронд байгуулсан бараа солилцооны гэрээнүүдийг судлан үзэхэд 2016-2017 онд байгууллага, хувь хүнтэй байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу 448.3 сая төгрөгийн хөрөнгө болон зардлыг бүртгээгүйгээс авлага хаагдаагүй байна. Энэ нь хариуцсан хэлтэс тасгуудын ажлын уялдаа хангалтгүй байгаатай холбоотой байна. /Судалгааг хавсралт 10-аас үзнэ үү./

2.44 Мөн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралтын 2-т “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг бараа, ажил тус бүр 10.0 сая төгрөг байна” гэсэн заалтыг зөрчиж 10 ААН-ийн нийт 578.7 сая төгрөгийн бараа солилцооны гэрээ байгуулсан байна. Тухайлбал,

- Тус компанийн нислэгийн үндсэн сэтгүүл болох “Хөөрөх цэг” сэтгүүлийг эрхлэн гаргадаг “Гранд Степп” ХХК-тай 2014 онд 179/014 дугаар гэрээг байгуулсан ба 2017 онд гэрээг 3 жилийн хугацаатай дахин сунгалт хийсэн байна. Уг гэрээг бараа солилцооны нөхцөлөөр хийсэн ба компани нь улирал тутам 4000 ширхэг жилд 16000 сэтгүүлийг нийлүүлдэг ба Захиалагч нь жилд 4 удаа өөрийн нислэгийн чиглэлдээ 100 хувь хөнгөлөлттэй (энэхүү хөнгөлөлтөд татварын хураамж ороогүй болно.) тийз, улирал тутам 250 кг ачаа үнэгүй тээвэрлэх эрх олгохоор тусгасан боловч өглөг авлагаар бүртгээгүй,
- Тус компани нь гэрээний хугацаанд 2014 оноос хойш 1 удаагийн тийзийн хөнгөлөлт буюу 4.5 сая төгрөгийн үйлчилгээ авсан ба бусад хөнгөлөлтийг эдлээгүй бөгөөд өглөг авлага үүсгэсэн нь санхүүгийн баримт байхгүй,
- Дүрэмт болон хөдөлмөр хамгааллын хувцасны /багц 1/, /багц-3/ тендер шалгаруулалтаар “Ууган Ананд” ХХК шалгарч 2017 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр 17/322 дугаар “Худалдах, худалдан авах” гэрээний дагуу бэлтгэн нийлүүлэгч компани гэрээний нийт төлбөрийн 50 хувь болох 111.2 сая төгрөгийн урьдчилгаа авч, 2017 оны 10 дугаар сарын 4-ний өдөр эхний ээлжинд нийлүүлэгдсэн гэгдэх 53.9 сая төгрөгийн бараа нь тооцоо нийлсэн актаар баталгаажигдаагүй,
- Уг барааг компани нь санхүүгийн бүртгэл тайланд тусгаагүй бөгөөд гэрээний 3.1-д “...албан ёсоор батлагдаж, дугаар авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор худалдан авагчийн захиалсан тоо хэмжээгээр нийлүүлнэ” заалтыг биелүүлээгүй, бараа нийлүүлэх хугацааг 69 хоногоор хоцроосон байна.



Тийзийн хөнгөлөлт олгохдоо холбогдох журмыг зөрчиж иржээ

2.45 Компанийн Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс тусгайлан эрх олгоогүй байхад 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн А/155 дугаар тушаалаар “Компанитай хамтран ажилладаг харилцагч байгууллага, албан тушаалтнуудад хөнгөлөлттэй нөхцөлөөр нислэгийн тийз олгох журам”-ыг батлан мөрдүүлж иржээ.

Энэ нь ТУЗ-ийн 2015 оны 6 дугаар сарын 10-ны 10/15 дугаар тогтоолоор баталсан “МИАТ” компанийн нислэгээр хөнгөлөлттэй тийзээр зорчих зөвшөөрөл олгох журам”-ын 2.8 дугаар заалтад “Хөнгөлөлтийг энэ журамд зааснаас өөр нөхцөлөөр тогтоох эрх нь ТУЗ-д байна” гэж заасныг зөрчжээ.

2.46 Компанитай хамтран ажилладаг харилцагч байгууллага, албан тушаалтнууд 339 хүнд 157 удаагийн хөнгөлөлтийн зөвшөөрөл олгохдоо ТУЗ-өөс баталсан журмын 5.3-т “Гадны байгууллага, хувь хүнд олон улсын болон орон нутгийн нислэгийн чиглэлд энгийн зэрэглэлийн суудлын хөнгөлөлтгүй тарифаас тооцон 90 хүртэлх хувийн хөнгөлөлтийг хүсэлт гаргагчийн төлбөрийн чадвар, хүсэлт гаргасан шалтгаан, нөхцөлийг харгалзан тийзийн хөнгөлөлт буюу дэмжлэгийг үзүүлж болно” гэж заасныг 46 удаа зөрчин 129 хүнд 100 хувийн хөнгөлөлтийн зөвшөөрөл олгосон байна.

Уг журмын 6.2-т “...Захирлын зөвлөлийн шийдвэрээр олон улсын нислэгийн чиглэлд 100 хүртэл хувийн тийзийн хөнгөлөлтийг ...олгож болно” гэж заасан ч Захирлын зөвлөлийн шийдвэр гараагүй бөгөөд Гүйцэтгэх захирлын баталсан журмын дагуу олгосон байна.

2.47 Гүйцэтгэх захирлын шийдвэрээр 2017 онд эрх бүхий албан тушаалтан, ажилтан (давхардсан тоогоор) болон тэдгээрийн гэр бүл болох 3222 хүнд 918 удаагийн хөнгөлөлтийн зөвшөөрөл олгохдоо:

Журмын 2.1-т “Энэхүү журмын 1.5, 1.7 дахь хэсэгт заасан хөнгөлөлттэй тийз хүсэх эрх бүхий албан тушаалтан, эрх бүхий ажилтан тэдгээрийн гэр бүлд жилд нэг удаа,...олгоно” гэж заасныг 175 удаа зөрчиж, 114 ажилтан, тэдгээрийн гэр бүлд (нийт 513 хүнд) 2-11 удаагийн хөнгөлөлтийн зөвшөөрлийг хэтрүүлж олгосон, журмын 1.7-д “Эрх бүхий ажилтан гэж “МИАТ” ТӨХК болон салбар, төлөөлөгчийн газарт 3-аас доошгүй жил тасралтгүй ажиллаж буй ажилтныг” гэж заасныг 60 удаа зөрчиж, ажилласан хугацаа хүрээгүй 60 ажилтанд, тэдгээрийн гэр бүлд (нийт 233 хүнд), хамааралгүй 8 хүнд 10 удаагийн (нийт 29 хүнд) хөнгөлөлтийн зөвшөөрөл олгосон байна. Журмын 2.2-т “Тэтгэвэрт гарсан өндөр настанд хоёр жилд нэг удаа олон улсын нислэгт энгийн зэрэглэлийн суудлын 100 хүртэл хувийн тийзийн хөнгөлөлтийг суудлын боломжтой нөхцөлөөр олгоно” гэж заасныг 4 удаа зөрчиж 3 хүнд (нийт 6 хүнд) 2-3 удаа олгосон.

Дээрх зөрчлийг тооцвол нийт 840.8 сая төгрөгийн хөнгөлөлтийн зөвшөөрлийг журам зөрчиж олгосон байна.

Эвлэрлийн гэрээ байгуулахыг урьтал болгосон нь компанийг өр төлбөрт оруулах нөхцөл болсон байна

2.48 Боинг-767 “JU1011” агаарын хөлгийг 2011 онд “ALC” компанитай 40 сарын хугацаатай түрээсээр ашиглах гэрээ байгуулсан байна. 2014 онд дээрх компани өөрийн өмчийн агаарын хөлгийг “Aersale” компанид худалдаж 2016 онд агаарын хөлөгт хөдөлгүүр, хөл ангийг сольж тавих нөхцөлтэй гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулан 2018 оны 9 дүгээр сар хүртэл сунгасан байна.

2.49 Гэрээний дагуу “Aersale” компанийн зүгээс санал болгосон хөдөлгүүр нь иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг хангаагүй тул эд ангиудыг суурилуулахаас татгалзаж, өмнөх эд ангийн хугацаа дуустал ашиглаж байгаад 2016 оны 6 дугаар сард агаарын хөлгийг өмчлөгчид нь хүлээлгэн өгсөн байна. Гэрээнд заасны дагуу тухайн агаарын хөлгийг ашиглаагүй байсан ч түрээсийн төлбөрийг төлөх (хатуу нөхцөлтэй) үүрэг хүлээсэн тул энэхүү заалтыг үндэслэн “Aersale” компани “МИАТ” ТӨХК-иас 9.7 сая ам.долларыг нэхэмжилж АНУ-ын шүүхэд хандсан байна.

2.50 Компанийн зүгээс хуулийн зөвлөгөө авах зорилгоор АНУ-ын “Pillsbury” компанитай гэрээ байгуулж ажилласан ба гэрээгээр нийт 258.6 мянган ам.долларыг үйлчилгээний хөлсөнд төлсөн байна. Энэ дагуу Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дэд захирлуудын санал, зөвлөгөөг харгалзан эвлэрлийн гэрээг байгуулсан байна.

Гэрээний дагуу сар бүр 100.0 мянган ам.доллар төлж байгаа бөгөөд 2017 оны 12 дугаар сарын байдлаар 1.5 сая ам.долларыг төлж 1.4 сая ам.долларын үлдэгдэлтэй ба төлбөрийг 2019 онд барагдуулж дуусахаар байна.

2.51 ИНЕГ болон МИАТ компани нь хөдөлгүүр, хөл эд анги нь манай улсын мөрддөг олон улсын стандарт, шаардлагыг хангаагүй талаар нотлох баримтыг бүрдүүлж шүүхийн байгууллагад хандаагүй, түрээсийн төлбөрийг ямар тохиолдолд төлөхгүй байх талаар гэрээнд тусгаагүй байна.

2.52 Иймд гүйцэтгэх удирдлагын эвлэрлийн гэрээ байгуулах болсон шийдвэрийг ТУЗ-ын хурлаар хэлэлцүүлж шүүхэд хандаагүй шалтгааныг тодруулах, удирдлагын шийдвэр буруу гэж үзвэл холбогдох албан тушаалтанд арга хэмжээ авах мөн гэрээний үлдэгдэл төлбөрийн асуудлыг багасгах эсвэл хүчингүй болгох асуудлаар нөгөө талтай тохиролцох саналыг дахин дэвшүүлэх шаардлагатай байна.

Цаашид агаарын хөлгийн түрээсийн гэрээг байгуулахдаа төлбөр төлөхгүй байх нөхцөл шалтгаануудыг тусгах, ээлжит техникийн шинэчлэл хийхээр бол өмчлөгч тал нь ИНЕГ болон “МИАТ” компанийн мөрдөж буй олон улсын стандартуудад нийцсэн хөдөлгүүр, хөл эд ангийг нийлүүлэх зэрэг бусад асуудлыг гэрээнд нарийвчлан тусгаж ирээдүйд гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь зүйтэй байна.

Урт болон богино хугацаат зээлийн эргэн төлөлттэй холбоотойгоор жил бүр ханшийн алдагдал үүсч байна

2.53 Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2012 онд 17.3 хувьд хүрч нүүрс, зэсийн үнэ оргил түвшинд байсан хэдий ч ирээдүйн чиг хандлага, эдийн засгийн тооцоо судалгаагүйгээр компанийн агаарын хөлгийн паркийг шинэчлэх зорилгоор 2013 онд 1ш “B767-300ER”, 2016 онд 2ш “B737-800” агаарын хөлгийг “Боинг” компаниас худалдан авах гэрээг 2011 оны 6 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгч АНУ-д хийсэн айлчлалын үеэр байгуулсан байна.

Гэвч санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал үргэлжилж эхний онгоцыг гэрээнд тусгагдсаны дагуу урт хугацаат зээлээр худалдан авч, 2016 онд авах 2 онгоцыг худалдан авах боломжгүй болсон байна.

2.54 2013 онд “B767-300 ER” агаарын хөлгийн үндсэн үнэ болох 185.8 сая ам.доллараас нийлүүлэгч талын танилцуулга, сурталчилгааны дагуу онгоцны их биеийн хөнгөлөлт 54 хувь, хөдөлгүүрийн хөнгөлөлт 52.9 хувь болон нийт 85.4 сая ам.долларын өндөр хөнгөлөлт эдэлж, нийт 100.3 сая ам.доллараар худалдан авсан боловч онгоц зуучлагч компаниар дамжуулан худалдан авсан бол илүү хямдаар авах боломж байсан байна.

Дээрх агаарын хөлгийг түрээсээр авч ашигласан бол компанийн тухайн онуудын ашиг орлого буурахгүйгээр зөвхөн түрээсийн зардалд 45.0 сая ам.долларыг төлөхөөр тооцоо судалгаа байгаа бөгөөд урт хугацаат зээлийн төлбөр нь компанийн эдийн засагт жил бүр дарамт учруулж мөн ханшийн алдагдал үүсгэж байна.

2.55 Зээлийн төлбөрт төлсөн үндсэн зээл, хүүгийн төлбөр, ханшийн зөрүүгийн алдагдлыг төгрөгт хөрвүүлэн авч үзвэл эхний 5 жилд дунджаар 190.6 тэрбум төгрөгийг төлсөн байгаа нь агаарын хөлгийн төлбөрийг бүрэн хийсэн, харин үлдэгдэл төлөгдөх ёстой 186.9 тэрбум төгрөгөөр дахин 1 агаарын хөлөг авах боломж харагдаж байна.

2.56 Төрөөс иргэний нисэхийн салбарт баримтлах бодлогын баримт бичгийн хүрээнд урт хугацаат зээлийн төлбөртэй холбоотой асуудлаар Засгийн газраас дэмжлэг үзүүлээгүй, УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны 2015 оны “Чиглэл өгөх тухай” тогтоолоор Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасан “МИАТ” ТӨХК-ийн худалдан авсан “Боинг 767-300ER болон худалдан авах “Боинг 737 MAX” маркийн онгоцны төлбөрийг Иргэний нисэхийн ерөнхий газрын навигацийн улсын төсөвт төвлөрүүлдэг орлогоос зээлийн гэрээний үндсэн дээр шийдвэрлэх” гэсэн заалт хэрэгжээгүй байна.

2.57 B767-300ER агаарын хөлгийг, зээлээр худалдан авахтай холбоотой зээлийг бүрэн төлж дуусах хүртэл АНУ-д бүртгэлтэй компанийн өмчид байх гэсэн шаардлага тавьсны дагуу ТӨХ-ны 2013 оны 5 дугаар сарын 09-ны “Хуулийн этгээд тусгаарлах” тухай 223 дугаар тогтоол, ТУЗ-ийн 2013 оны 5 дугаар сарын 6-ны 14/13 дугаар тогтоолоор тусгай зориулалтын компани байгуулах талаар МИАТ компанид зөвшөөрөл олгож, АНУ-ын Дэлавэр мужид бүртгэлтэй “MNG” Лизинг компанийг 1 ам.долларын хөрөнгөтэйгөөр SPC буюу тусгай зориулалтын компани байгуулсан байна.

2.58 Тус компанийн өмчид “B767-300 ER” онгоцны өмчлөх эрхийг 1 ам.доллараар үнэлж бүртгэсэн ба агаарын хөлгийн зээлийн эргэн төлөлтийг бүрэн барагдуулсны дараа МИАТ компанийн өмчид шилжүүлэхээр байна.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид тусгай зориулалтын компанийн тухай ойлголт байхгүй нь агаарын хөлгийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлэхэд хүндрэл учруулж байна.

2.59 Компани 2013 оны 5 дугаар сард агаарын хөлгийг хүлээн авч төлбөрийг төлөхийн тулд Монгол Улсын Засгийн газраас АНУ-ын Экспорт-Импорт банканд баталгаа гаргаж тус банк нь “Экспорт Санхүүжилтийн Корпораци”, “Ай Эн Жи Капитал” ХХК, “Ай Эн Жи” зэрэг зээлдэгч банкуудад өөрийн баталгааг гаргасны дагуу нийт 121.4 сая ам.долларын урт хугацааны зээлийг авсан байна.

Урт хугацааны зээлийг хүснэгтээр харуулбал,

Хүснэгт 13

№	Зээлийн төрөл	Санхүүжүүлэгч байгууллага	Зээлийн хэмжээ /ам.доллар/	Зээлийн хүү /жилээр/	Эхлэх огноо	Дуусах огноо	Хугацаа /жилээр
1	Үндсэн зээл	Экспорт Санхүүжүүлэлтийн Хувийн корпораци	77,451,941.47	2.52 % /Тогтмол/	2013.12.24	2023.05.13	10
2	Дэд зээл	Ай Эн Жи Капитал ХХК	23,963,637.89	5.54 % /хөвөгч /	2013.12.24	2020.11.13	7
3	Баталгаат өрийн бичиг	Ай Эн Жи Банк	20,000,000.0	9.62 % /хөвөгч/	2013.12.23	2018.12.23	5
Нийт авсан зээлийн хэмжээ			121,415,579.36				

2.60 Тус агаарын хөлгийн гадаад зээлийн эргэн төлөлт улирлаар хийгддэг бөгөөд 2013-2017 онуудад үндсэн зээлийн төлбөрт 49.1 сая ам.доллар, хүүгийн төлбөрт 18.6 сая ам.доллар нийт 67.8 сая ам.доллар төлж ханшийн зөрүүгийн алдагдалд 40.6 тэрбум төгрөг хүлээсэн байна.

Зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэр,

Хүснэгт 14

Төлөлтийн эх үүсвэр	Төлсөн огноо	Хэмжээ/ам.доллар/
Компанийн үйл ажиллагааны орлогоос	2013-2017	47,293,050.01
Худалдаа хөгжлийн банк	2014	4,166,813.62
МУ-ын Хөгжлийн банк/3 удаа зээл авсан/	2014,2015	12,257,314.50
МУ-ын Сангийн яам	2014	4,166,746.44
Зээлийн эргэн төлөлтийн санхүүжилтийн нийт дүн	-	67,883,924.57

2.61 Компани урт хугацаат зээлийн эргэн төлөлтөд зориулж 7.5 тэрбум төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас буцаан төлөх нөхцөлтэйгөөр Сангийн яамтай гэрээ байгуулж авсан. Уг зээлээс ямар нэгэн хүү тооцоогүй ба зээлийн эргэн төлөлтийг НӨАТ-ын буцаан авалтаас суутган авахаар заасны дагуу 2013-2016 онд 3.6 тэрбум төгрөгийг зээлд суутгуулж, үлдэгдэл 3.9 тэрбум төгрөг гэрээнд заасан зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтрүүлсэн хоног тутам алданги тооцож 1.4 тэрбум төгрөг нийт 5.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2013-2017 онуудад зээлийн эргэн төлөлтийг өөрийн орлогоос болон богино хугацаат зээлээр төлж барагдуулсан байна.

Зээлийн эргэн төлөлт ба хуваарийг харуулбал,

Хүснэгт-15

Он	/2017.12.31-ний өдрийн байдлаар /ам.доллар/			
	Үндсэн зээл	Дэд зээл	Баталгаат өрийн бичиг	Нийт
2018 – 2023 оны зээлийн эргэн төлөлтийн хуваарь				
2018	\$ 9,167,823.27	\$ 3,879,952.58	\$ 21,935,865.39	\$ 34,983,641.24
2019	\$ 8,959,375.63	\$ 3,687,460.35	-	\$ 12,646,835.98
2020	\$ 8,757,205.69	\$ 2,639,519.45	-	\$ 11,396,725.14
2021	\$ 8,540,054.91	-	-	\$ 8,540,054.91
2022	\$ 8,334,175.41	-	-	\$ 8,334,175.41
2023	\$ 2,051,192.23	-	-	\$ 2,051,192.23
Нийт	\$ 45,809,827.14	\$ 10,206,932.38	\$ 21,935,865.39	\$ 77,952,624.91

2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн нийт үлдэгдэл 77.9 сая ам.доллар байна.

Түрээсийн төлбөр нь насжилт, хугацаа, багтаамж зэргээс хамаарч харилцан адилгүй байна

2.62 Тус Компани агаарын тээвэр эрхлэгч авиа компаниудтай урт болон богино хугацааны түрээсийн гэрээг байгуулан 2017 оны байдлаар нийт 5 түрээсийн онгоцыг үйлчилгээндээ ашиглаж байна.

Түрээсийн мэдээллийг харуулбал,

Хүснэгт-16

№	Онгоцны төрөл	Бүртгэл ийн №	Үйлдвэрлэсэн		Агаарын хөлгийн өмчлөгч	Түрээс сар бүр	Барьцаа	Гэрээний хугацаа /он./	
			он	насжилт				Эхлэх	Дуусах
2	B737-800	JU-1015	2014	4	ALC BLARNEY. Ireland	399.000	2,904.000	2014	2028
3	B737-800	EI-CSG	2000	18	CIT CAPITAL AVIATION UK.LTD	230.000	690.000	2008	2019
4	B737-800	EI-CXV	2002	16	Macquarie Ireland	230.000	719.975	2002	2020
5	B737-700	JU-1087	2002	16	Oman Air-Air Castle	165.000	495.000	2017	2019

2.63 Агаарын хөлгийн түрээсийн төлбөр нь түрээслэх агаарын хөлгийн насжилт (*ИНЕГ-аас гаргасан дүрэм журамд зааснаар манай улсад 20 жилээс дээш насжилттай агаарын хөлгийг ашиглахыг хориглодог байна.*) суудлын тоо болон бусад үзүүлэлтийг харгалзан үзэж түрээсийн төлбөрийг харилцан тохиролцдог ба гэрээнд зааснаар тодорхой хугацаанд төлбөр нэмэгдэх хасагдах нөхцөлүүдийг тусгасан ба 2017 оны байдлаар түрээсийн төлбөрт сар бүр нийт 1.2 сая ам.доллар төлж байна.

2.64 Жил ирэх тусам агаарын тээврээр үйлчлүүлэгчдийн тоо өсч байгаатай холбоотойгоор “Oman Air” компаниас 16 жилийн насжилттай “B737-700” маркийн агаарын хөлгийг 2017 оноос 2019 он хүртэл 2 жилийн хугацаатай авсан ба Компани 2019 онд 2 агаарын хөлөг, 2020 онд дахин 2 шинэ агаарын хөлөг түрээслэхээр гэрээ хэлцэл хийгдэж байна.

Агаарын хөлгийн түрээсийн төлбөрт төлсөн дүнг онгоц тус бүрээр харуулбал,

Хүснэгт-17

№	Агаарын хөлөг	Өмнөх онуудад нийт	/мянган.ам доллар/	
			2016 оны түрээсийн төлбөр	2017 оны түрээсийн төлбөр
1	B767-300 EI-FGN	-	1,720.0	2,580.0
2	B737-800 JU-1015	7,980.0	4,788.0	5,022.0
3	B737-800 EI-CSG	30,887.2	2,760.0	2,760.0
4	B737-800 EI-CXV	41,010.0	2,784.0	2,832.0
5	B737-700 JU-1087	-	-	1,272.0
6	Нийт дүн	79,877.2	12,052.0	14,466.0



Компани агаарын хөлгийн түрээсийн төлбөрт 2017 оны эцсийн байдлаар нийт 106.4 сая ам.долларыг төлсөн байна.

Катеринг төвийг удирдлагын үндсэн гэрээний хугацаа дууссан байхад нэмэлт гэрээ байгуулсан, барьцаа төлбөрийг үндэслэлгүйгээр буцаан олгосон байна.

2.65 Компанийн Катеринг төвийн удирдах үйл ажиллагааг удирдлагын гэрээгээр гүйцэтгэх этгээдийг сонгон шалгаруулалтаар “Нүхт Тур” ХХК шалгарч 2009 оны 7 дугаар сарын 23-ны өдөр удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэх 09/131 дүгээр гэрээг байгуулжээ.

2.66 Гүйцэтгэгч тал удирдлагын гэрээний үүргийн биелэлтийг хангах, гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйд хүлээлгэх хариуцлага, учруулсан хохирлыг нөхөн төлөх баталгаа болгон 250.0 мянган ам.долларыг Худалдаа хөгжлийн банкны “МИАТ” компанийн дансанд байршуулж, 250.0 мянган ам.долларын үл хөдлөх хөрөнгө буюу нийт 500.0 мянган ам.долларын хөрөнгийг гэрээний дагуу байршуулсан байна. Гэтэл 2017 оны байдлаар 250.0 мянган ам.долларын үнэ бүхий ямар төрлийн үл хөдлөх хөрөнгө барьцаанд тавьсан болон гэрчилгээний хуулбар, бусад холбогдох баримт, материал “МИАТ” компанид алга байна.

2.67 Компани “Нүхт-тур” ХХК хооронд “Эскроу” буюу дундын дансанд байршуулсан 250.0 мянган ам.долларыг компанийн гүйцэтгэх захирлын 2012 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 01/2510 дугаар тушаалаар уг дансыг хааж, барьцааны хөрөнгийг тус компанид буцаан олгосон байна.

Гэрээнд заасан барьцааг буцаан олгосон нь Иргэний хуулийн 161 дүгээр зүйлийн 161.1¹²-т заасан эрхийг хязгаарласан, гэрээний 16 дугаар зүйлийн 16.1.1(б)¹³-т заасан гэрээ цуцлах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Уг гэрээг 2009-2017 он хүртэл гэрээний сунгалтыг жил бүр хийж ирсэн бөгөөд 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр үндсэн гэрээний хугацаа дууссан боловч үргэлжлүүлэн сунгалтууд хийсэн нь гэрээний 2 дугаар зүйлийн 2.1¹⁴ дэх заалтыг зөрчсөн тул гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэхээр байна.

Катерингийн үйлчилгээ үзүүлж байгаа компани эхний 3 жил түрээсийн төлбөр төлөөгүй байна

2.68 Тус компани 2009 оноос эхлэн түрээсийн төлбөр төлөөгүй ба 2012 оны 6 дугаар сарын 11-ний өдөр “Төрийн өмчийн хорооноос 46/13 дугаар “Төр өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ”-г “Нүхт тур” ХХК-тай байгуулан ажилласан ба гэрээгээр сар бүр түрээсийн төлбөр төлдөг болсон байна.

Түрээсийн төлбөрийн хэмжээг 1 сарын 5.3 сая төгрөгөөр тогтоож 2013 оны 4 дүгээр сараас 13.6 сая төгрөг, 2017 оны 11 сараас 18.2 сая төгрөг болгон нэмэгдүүлсэн ба компани сүүлийн 6 жилийн хугацаанд нийт 985.5 сая төгрөгийг түрээсийн төлбөрт төлсөн байна.

2.69 Катерингийн төвөөс авсан үйлчилгээний төлбөрт компаниас 2009-2017 он хүртэлх хугацаанд нийт 30.9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Тухайлбал 2016 онд 5.1 тэрбум төгрөг, 2017 онд 6.8 тэрбум төгрөг болж өссөн байна.

¹² Үүрэг гүйцэтгүүлэгч барьцаагаар хангагдах шаардлагыг шилжүүлэх замаар барьцааны эрхээ бусдад шилжүүлж болно

¹³ Гүйцэтгэгч тал энэхүү гэрээгээр хүлээсэн биелүүлэх ёстой байсан үүргээ ямар нэг хэмжээгээр биелүүлээгүй, хангалтгүй биелүүлсэн болон зөрчсөн тохиолдолд гэрээг үл маргах журмаар цуцлах.

¹⁴ 2.1.2 Гэрээний заалтын дагуу хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгоогүй бол энэхүү гэрээний хүчинтэй хугацаа 2 /хоёр/ жил байна.

2.1.3 Гэрээг 2 /хоёр/ жилийн хугацаатайгаар 2 /хоёр/ удаа сунгаж болно.

Бүлэг 3. Компанид өмнө нь хийгдэж байсан хөндлөнгийн хяналт шалгалтууд түүний мөрөөр авсан арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна

3.1 Аюулгүй ажиллагаа, чанар аюулгүй байдлын алба /ААЧАБА/ нь 18 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа гүйцэтгэж байгаагийн харьяанд дотоод аудиторыг 1 хүний орон тоотой ажиллуулж байна.

3.2 Дотоод аудитор нь тайлант хугацаанд санхүү бүртгэлийн үйл ажиллагааны хууль тогтоомж, дүрэм журам, холбогдох гэрээний мөрдөлтийн байдал, илэрсэн зөрчил дутагдалд хууль тогтоомжийн дагуу дүгнэлт гарган удирдлагуудад танилцуулан компанийн санхүүгийн үйл ажиллагааг зүй зохистой зохион байгуулахад зөвлөмж өгч, дэмжлэг үзүүлэн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд нийт 23 удаа аудит хийсэн байна.

3.3 Үүнээс төлөвлөгөөт шалгалт 12, төлөвлөгөөт бус шалгалт 8, гомдол 1, албан бичгийн дагуу 2 шалгалтыг тус тус хийжээ.

3.4 ААЧАБА Алба компанид ашиглагдаж байгаа бүх агаарын хөлгүүдийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ тэдгээрийн дагалдах гэрчилгээнүүдийг хүчин төгөлдөр хадгалж, агаарын хөлгийн түрээслүүлэгч компаниудаас ирсэн аудит шалгалтуудад амжилттай шалгуулсан байна.

“Боинг 737-800” агаарын хөлгийн ослын улмаас хөдөлгүүр эвдэрсэн ба засвар хийлгэх хугацаанд шинээр нэмэлт хөдөлгүүр түрээслэн авч төлөвлөгдөөгүй зардал гаргажээ

3.5 Компани “B737-800” E1-CXV бүртгэлийн дугаартай агаарын хөлөг 2016 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Ховд аймгийн нисэх буудлын зурвасаар хөөрөхөөр гүйлт үйлдэх үедээ чиг алдаж зурвасаас гарч замын хажуугийн гэрлийн богино шонг мөргөсөн, замаас гарч эд анги чулуунд цохигдон олон тооны хонхойлт үүссэн, эд анги хэд хэдэн газар цохигдож гэмтсэн, хөдөлгүүрт шороо орсон зэрэг гэмтэл үүссэн байна.

Бүгд Найрамдах Ирланд Улсын агаарын хөлгийн гэмтэл ослын шалтгааны шинжлэн судлах байгууллагаас “МИАТ” компанийн нисэх бүрэлдэхүүн болон ИНЕГ-ын Ховд аймгийн нисэх буудлын буух хөөрөх зурвасын зөвшөөрлийг шалгахад дараах зөрчил дутагдал илэрсэн байна.

- Нисэх багийн бүрэлдэхүүн агаарын хөлөг зурвасаас хөдөлж чиг алдсан үед зогсолт хийх арга хэмжээг аваагүй,
- ИНЕГ нь Аэродромын гэрчилгээг 2014 оны 10 дугаар сарын 1-нд 1 жилийн хугацаатай олгосон ба 2016 оны 10 дугаар сар хүртэл сунгаж Ховд аймгийн нисэх буудлын аэродромыг олон улсын 4С ангилалын аэродром болгох талаар заасан боловч тухайн ажил хийгдээгүй, хөөрч буух хатуу хучилттай зурвасын өргөний даацыг бүрэн тодорхойлоогүй нь шинжлэн шалгасан дүгнэлтээр тодорхой болсон байна.

Уг дүгнэлтийг үндэслэн Гүйцэтгэх захирлын 2017 оны 3 дугаар 28-ны өдрийн Б/239 дүгээр тушаалаар “Албан тушаал бууруулах, сахилгын шийтгэл ногдуулах тухай” арга хэмжээг тухайн нисгэгч нарт авсан байна.

Дээрх агаарын хөлгийн хөдөлгүүрийг “Боинг” компанийн засварын газарт илгээсэн ба эвдрэлтэй холбоотойгоор гарах зардлыг давхар даатгагчаас (*Монгол даатгал компани нь цаашаа олон улсын даатгалын компанитай давхар даатгалын гэрээ байгуулдаг байна.*) хөдөлгүүр засварын компанид 3.2 сая ам.доллар шилжүүлсэн байна.

3.6 7B26 маркийн хөдөлгүүрийг 2016 оны 5 дугаар сарын 20-ноос 2017 оны 3 дугаар сарын 27-ны хооронд 1 сарын 58.0 мянган ам.доллараар түрээслэн авч нийт 594.7 мянган ам.долларыг зарцуулсан байна.

Дээрх төлбөртэй холбоотойгоор “МИАТ” компани хөдөлгүүр нь эвдэрсэн агаарын хөлгийн зорчигчдыг Ховд аймгийн нисэх буудлаас Улаанбаатар хот руу тээвэрлэсэн захиалгат нислэгийн төлбөр 31.3 мянган ам.доллар, хөдөлгүүр засварлах хугацаанд хөдөлгүүр түрээслэсэн төлбөрт 536.6 мянган ам.доллар нийт 567.9 мянган ам.долларын зардлыг



“Монгол даатгал” ХХК-иас гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан нь аудитын хугацаанд эцэслэн дуусаагүй болно.

3.7 Тус компанийн санхүүгийн үйл ажиллагаанд өмнө нь Сангийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Төрийн өмчийн хорооноос удаа дараа шалгалт хийгдэж байсан боловч үр дүн хангалтгүй, зөрчил дутагдал жил бүр дахин давтан гарсаар байна.

Дээрх байдалд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар тухайн оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тус компаниас ирүүлсэн зорилтын санал, тоо мэдээлэл, судалгааг нарийвчлан хянаж, үр дүн, үр ашгийн бодит үндэслэлийг тооцолгүй шууд батлан өгч буй жишиг хандлага ч нөлөөлж байна.

3.8 Сангийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Төрийн өмчийн хорооноос тус компанийн 2005-2011 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зарим зөрчил дутагдал бүрэн арилаагүй, тухайн шалгалтын ажлын хэсгийн тайлан компанид алга байна.

3.9 Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын баталсан төлөвлөгөөний дагуу Төрийн өмчийн бүртгэл хяналтын хэлтсээс тус компанийн 2014, 2015, 2016 оны 3 дугаар улирлын байдлаарх үйлдвэрлэл, санхүү эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 50.5 тэрбум төгрөгийн зөрчил, дутагдал илэрч, ТӨБЗГ-ын даргын 2017 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 508 дугаартай “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” тогтоол гарч, дээрх зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар батлан биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг “МИАТ” компанид даалгажээ.

3.10 “МИАТ” компаниас 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 01/705 дугаартай албан бичгээр дээрх шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний танилцуулгыг хүргүүлэхдээ биелэлтийг хэрэгжих боломжгүй гэж тайлбарласан, илэрсэн зөрчил дутагдлыг үгүйсгэн дээрх зөрчил дутагдал нь дахин давтагдах магадлалтай байгаа талаар ТӨБЗГ-т ханджээ. Тухайлбал,

- Нислэгийн хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой цаг хугацааны хувьд хойшлуулах боломжгүй зайлшгүй худалдан авалт хийх шаардлага гардаг. Дээрх онцлогоос хамааран агаарын тээврийн үйл ажиллагааг хэвийн явуулахад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах боломжгүйг тайлбарлаж шууд гэрээний болон харьцуулалтын аргаар худалдан авалт хийхэд хууль, эрх зүйн хувьд дэмжлэг үзүүлэх талаар саналаа ирүүлжээ.

3.11 Түүнчлэн иргэний агаарын тээвэр нь өөрөө онцгой үйлчилгээ учраас агаарын хөлөгт хэрэглэж буй нэг удаагийн, хуурай, даавуун хэрэглэл, үйлчилгээний жижиг тоног төхөөрөмж, агааржуулагч, шавж устгагч гээд бүхий л бараа бүтээгдэхүүн, түүхий эд нь олон улсын агаарын тээврийн байгууллагын дүрэмд заасан аюулгүй ажиллагааны болон тохирлын, гарал үүслийн гэрчилгээтэй байх шаардлагатай гэсэн байна.

Компанийн өр төлбөрийг төлж барагдуулахад шаардагдах санхүүгийн нөөц хүрэлцэхгүй байна

1. Компанийн хөрөнгийн бүрэлдэхүүний динамик шинжилгээ,

Хүснэгт-18

/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2016 он	Хувь	2017 он	Хувь	Өөрчлөлт	
					Тоогоор	Хувиар
Хөрөнгийн бүрэлдэхүүн						
Эргэлтийн хөрөнгө	94.5	35.4	114.3	39.8	19.8	20.9
Эргэлтийн бус хөрөнгө	172.2	64.6	172.7	60.2	0.5	0.3
Дүн	266.7	100.0	287.0	100.0	20.3	7.6
Эх үүсвэр						
Өр төлбөр	335.9	125.9	306.0	106.6	(29.9)	(8.9)
Эзэмшигчийн өмч	(69.2)	(25.9)	(19.1)	(6.6)	50.1	(27.6)
Дүн	266.7	100.0	287.0	100.0	20.3	7.6

Компанийн эргэлтийн хөрөнгө өмнөх оноос 20.9 хувиар өссөн нь мөнгөн хөрөнгө, материалын өсөлт нөлөөлсөн. Нийт өр төлбөр 8.9 хувиар буурсан нь гадаад дотоодын зээлийг хуваарийн дагуу төлсөн нь нөлөөлсөн байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс зээлийн эргэн төлөлтөд зориулж 24.0 тэрбум төгрөг, 1.5 сая долларын хугацаатай хадгаламжид байршуулсан байна. Авлага өссөн нь борлуулалтын орлогын өсөлтөөс хамаарч байгаа сайн үзүүлэлт хэдий ч нөгөө талдаа алдагдсан боломжийн зардлыг өсгөх сөрөг талтай. Бараа материалын хувьд онгоцны багаж, сэлбэг хэрэгслийн татан авалтын өсөлт нөлөөлсөн байна. Нийт хөрөнгийн 46 хувийг худалдан авсан агаарын хөлөг эзэлж байна.

2. Төлбөрийн чадварын шинжилгээ

Хүснэгт-19

Үзүүлэлт	2016	2017	Өөрчлөлт
Цэвэр эргэлтийн хөрөнгө	(54.4)	(66.2)	
Эргэлтийн харьцаа	0.6	0.6	(0.00)
Хурдан хөрвөх харьцаа	0.4	0.4	0.03

Хүснэгтээс үзэхэд хурдан хөрвөх хөрөнгийн харьцаа 0.03 пунктээр өссөн хэдий ч өр төлбөрөө барагдуулахад эргэлтийн хөрөнгүүд хүрэлцэхүйц бус байна. Гүйлгээгүй нөөц буюу авлага, бараа материал өссөнтэй холбоотой.

3. Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ

Хүснэгт-20

Үзүүлэлт	2016	2017	Өөрчлөлт
Бие даалтын коэффициент	(0.26)	(0.07)	0.19
Санхүүгийн хамаарлын коэффициент	(3.85)	(15.06)	(11.21)
Зохицуулалтын коэффициент	0.79	3.47	2.69
Өөрийн ба гадны капиталын харьцаа	(4.85)	(16.06)	(11.21)
Гадны капиталын хувийн жин	1.26	1.07	(0.19)
Байнгын капиталын бүтэц	1.09	0.73	(0.36)
Гадны капиталын бүтэц	0.56	0.41	(0.15)

Коэффициентууд хасахтай гарсан нь гадны эх үүсвэрээс бүрэн хараат буюу өөрийн капиталын нэгжид ногдох гадаад эх үүсвэр их байна. Өр төлбөрийн хувийн жин 1-ээс бага байгаа нь өр төлбөр нийт хөрөнгөөс давсныг харуулах бөгөөд гадны эх үүсвэрээс хараат бусаар, зөвхөн өөрийн санхүүжилтээр бие дааж үйл ажиллагаа явуулах чадваргүй байгааг илэрхийлж байна.

4. Эргэцийн шинжилгээ

Хүснэгт-21

Үзүүлэлт	2016	2017	Өөрчлөлт
Авлагын эргэц /удаа/	12.09	14.34	2.25
Авлагын эргэц /өдөр/	29.78	25.11	(4.67)
Нөөцийн эргэц /удаа/	8.35	9.46	1.12
Нөөцийн эргэц /өдөр/	43.13	38.05	(5.08)
Эргэлтийн хөрөнгийн эргэц /удаа/	3.40	3.43	0.03
Эргэлтийн хөрөнгийн эргэц /өдөр/	105.92	104.96	(0.96)
Нөөц хөрөнгийн эргэц	1.20	1.37	0.16
Өглөгийн эргэц /удаа/	0.65	0.99	0.34
Өглөгийн эргэц /өдөр/	553.54	365.03	(188.52)
Үйлдвэрлэлийн циклийн хугацаа	72.91	63.16	(9.75)
Санхүүгийн циклийн хугацаа	(480.63)	(301.87)	178.77

Авлагын эргэц 2.3 удаагаар өсч, 4.7 өдрөөр буурсан, нөөцийн эргэц 1.1 удаагаар нэмэгдэж, 5 өдрөөр буурсан нь үйлдвэрлэлийн циклийн хугацаа өмнөх оноос 9.7 өдрөөр

багасгахад нөлөөлсөн. Өглөгийн эргэц 188.5 өдрөөр буурч, санхүүгийн циклийн хугацаа 178.8 өдрөөр нэмэгдсэн байна. 1 төгрөгийн хөрөнгө тутмаас 1.37 төгрөгийн орлого олж байна.

5. Хөрөнгө капиталын ачааллын шинжилгээ
Хүснэгт-22

Үзүүлэлт	2016	2017	Өөрчлөлт
Үндсэн хөрөнгийн ачаалал	1.88	2.30	0.42
Өөрийн хөрөнгийн ачаалал	(4.64)	(20.57)	(15.93)

Компанид ашиглагдаж буй үндсэн хөрөнгийн 1 төгрөг тутамд 2.3 төгрөгийн орлого олж байна. Уг үзүүлэлт нь жил бүр өсч байгаа нь хөрөнгийн ашиглалт сайжирч байгааг илтгэж байна. Эзэмшигчийн өмчийн ашиглалтын түвшин хасах утгатай байгаа нь компанийн хөрөнгийн эх үүсвэр гадны зээлдүүлэгчдийн хөрөнгийг ашиглаж байгааг харуулж байна.

6. Ашигт ажиллагааны шинжилгээ

Хүснэгт-23

Үзүүлэлт	2016	2017	Өөрчлөлт
Борлуулалтын ашигт ажиллагаа	0.26	0.22	(0.03)
Үндсэн үйл ажиллагааны ашигт ажиллагаа	1.34	1.29	(0.06)
Хөрөнгийн ашигт ажиллагаа	(0.00)	0.17	0.18
Өөрийн капиталын ашигт ажиллагаа	0.02	(2.63)	(2.65)

1 төгрөгийн оруулсан хөрөнгөөс 0.22 төгрөгийн ашиг олж байгаа бөгөөд өмнөх оноос 0.03 пунктээр буурсан байна. Үндсэн үйл ажиллагааны ашигт ажиллагаа 0.06 пунктээр буурч, хөрөнгийн ашигт ажиллагаа 0.18 пунктээр өсөхөд борлуулалтын орлого, цэвэр ашиг нэмэгдсэн нь нөлөөлжээ.

7. Мөнгөн урсгалын шинжилгээ

Хүснэгт-24

Үзүүлэлт	2016	2017	Өөрчлөлт
Цэвэр эргэлтийн хөрөнгө ба борлуулалтын харьцаа	(0.18)	(0.17)	0.01
Цэвэр эргэлтийн хөрөнгө ба нийт хөрөнгийн харьцаа	(0.20)	(0.23)	(0.03)
Мөнгөн орлого ба борлуулалтын харьцаа	1.00	1.01	0.00
Мөнгөн орлого ба хөрөнгийн харьцаа	1.11	1.36	0.26
Мөнгөн зарлага ба борлуулалтын харьцаа	0.86	0.88	0.02

Дээрх харьцаануудын өөрчлөлт нь борлуулалтын орлого өмнөх оноос 33 хувиар өссөнтэй холбоотой байна.



Холбогдох байгууллагын санал



Санал хүргүүлэх тухай
 Танай 2018 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 01/867 дугаар албан бичгээр ирүүлсэн тайлангийн төсөлтэй танилцлаа.

Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-д заасны дагуу тайлангийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна:

1. Төслийн 1.17, 1.18 дахь хэсгийг тус тус хасах;

Тайлбар: Компанийн тухай хуулийн 78.3 дахь хэсэгт “Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг түр эзгүйд түүний үүргийг төлөөлөн удирдах зөвлөлийн даргын, эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн томилсон гишүүн гүйцэтгэнэ.” гэж заасан. Уг заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 7 дугаар хурлыг 2015 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Төрийн өмчийн хорооны хурлын танхимд гишүүдийн 67 хувийн ирцтэй хийсэн ба хуралдаан даргалагчийг гишүүдийн дотроос олонхийн саналаар сонгож хуралдсан.

Компанийн тухай хуулийн 80.2 дахь хэсэгт “Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын дарга гарын үсэг зурна.” гэж заасан бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөл нь хамтын шийдвэр гаргадаг институци бөгөөд хурлын дарга, эсхүл аль нэг гишүүн дангаараа шийдвэр гаргадаггүй. Мөн хуулийн 80.5 дахь хэсэгт “Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал гишүүдийнх нь дийлэнх олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно” гэж, 80.6 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй, эсхүл компанийн дүрмээр тусгайлан өндөр хувь тогтоогоогүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.” гэж тус тус заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 14/15 дугаар тогтоолд тухайн хуралд оролцсон бүх гишүүн дэмжиж, гарын үсэг зурсан.

2. Төслийн 1.21 дэх хэсгийг хасах;

Тайлбар: Компанийн тухай хуулийн 78.1 дэх хэсэгт “Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүний олонхийн саналаар сонгоно.” гэж заасан.

“МИАТ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 79, 80 дугаар тогтоолоор томилж, чөлөөлсөн ба шинэлэгдсэн Төлөөлөн удирдах зөвлөл 2016 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хурлын танхимд 67 хувийн ирцтэйгээр хуралдсан. Тухайн хуралд ТӨБЗГ-ын Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга оролцон 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 79, 80 дугаар тогтоол, 2016 оны 10 дугаар сарын 13-

001716



ны өдрийн 1/350 дугаар удирдамжийг танилцуулсан ба Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар сонгож, баталсан.

Дээрх саналыг хүлээн авч, тайлангийн төсөлд холбогдох засвар, өөрчлөлт оруулахыг Танаас хүсье.

Жич: Дурьдсан саналуудын хувьд Төрийн өмчийн хороо /хуучнаар/-ны эрх хэмжээний асуудал тул Гүйцэтгэх удирдлагаас тайлбар хийх нь зохимжгүй бөгөөд тухайн асуудалтай холбоотойгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас нэмэлт тодруулга, тайлбар авах нь зүйтэй юм. Шалгалтын үеэр аудитын багт тухайн үеийн хурлын тэмдэглэл, тогтоолыг гаргаж өгсөн болно.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Т.ТАМИР

Тайлбарын дугаар	Саналыг хүлээн авсан эсэх	Тайлбар
Тайлбар №1	Тийм	Саналыг хүлээн авч тайланд засвар оруулсан болно.
Тайлбар №2	Үгүй	Компанийн дүрэм, ТУЗ-ын үйл ажиллагааны журам нь Компанийн тухай болон ТБОНӨТ хуультай нийцэхгүй байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

Дүгнэлт

“Монголын Иргэний Агаарын Тээвэр” төрийн өмчит хувьцаат компанийн 2016-2017 оны үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитыг дараах зорилтын хүрээнд гүйцэтгэж дараах дүгнэлтийг өглөө. Үүнд:

- “МИАТ” ТӨХК нийт 6 агаарын хөлгөөр олон улсын чиглэлийн нислэг үйлдэж байгаа боловч бүтэц, зохион байгуулалт нүсэр, тээврийн бус олон туслах үйлчилгээтэй, боловсон хүчин, үйл ажиллагаанд улс төр, бизнесийн оролцоо, нөлөөлөл их, зарим алдагдалтай чиглэлийг авч явж, ашигтай чиглэлийн орлогоос нөхдөг, үйл ажиллагааны менежмент, маркетингийн бодлого, зохицуулалт бусад компанитай өрсөлдөхүйц бус байна.
- Монгол Улсын эдийн засгийн өсөлт өндөр байх үед ирээдүйн чиг хандлага, эдийн засгийн үр ашгийг тооцолгүйгээр “Боинг” компаниас 2013 онд 1 ш “B767-300ER”, 2016 онд 2ш “B737-800” агаарын хөлгийг худалдан авахаар 2011 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн хийсэн айлчлалын үеэр гэрээ байгуулсан боловч санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал үргэлжилж эхний онгоцыг урт хугацаат зээлээр худалдан авч дараагийн 2 онгоцыг худалдан авах боломжгүй болсон нь компанийн эдийн засагт жил бүр дарамт учруулж ханшийн алдагдал үүсгэсээр байна.
- УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны 2015 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 21 дүгээр “Чиглэл өгөх тухай” тогтоолоор Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасан “МИАТ” ТӨХК-ийн худалдан авсан “Боинг 767-300ER болон худалдан авах “Боинг 737 MAX” маркийн онгоцны төлбөрийг Иргэний нисэхийн ерөнхий газрын навигацийн улсын төсөвт төвлөрүүлдэг орлогоос зээлийн гэрээний үндсэн дээр шийдвэрлэх” гэсэн заалт хэрэгжээгүй байна.
- Эдийн засаг, улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалж олон улсын чиглэлд агаарын тээврийн зах зээл дорвитой өсч тэлээгүй байхад сүүлийн жилүүдэд гадаадын хэд хэдэн агаарын тээвэрлэгч орж ирсэн буюу нэмж нислэг үйлдэх шаардлага тавьж байгаа нь үндэсний тээвэрлэгч компани гадаад чиглэлд боломжит орлогоо алдахад нөлөөлж байна.
- Гадны тээвэрлэгчдэд давуу эрх олгосноос үүсэх сөрөг үр дагавраас үндэсний эрх ашигт хохирол учирсан жишээ сургамжуудыг авч үзэн зорчигчийн урсгалын өсөлтийн хандлага, олон улсын тээвэрлэлтийн чиглэл, нислэгийн багтаамж, давтамжийн төлөвлөлтийг хийсний дагуу агаарын яриа хэлэлцээ хийж үйл ажиллагааг зохион байгуулах, үүнд улс төр, бизнесийн болон гадаадын агаарын тээвэрлэгчдийн бодлогын нөлөөллөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.
- ТӨБЗГ болон ТУЗ-өөс компанийн эдийн засгийн үзүүлэлт, нислэг үйлдвэрлэлийн хэмжээтэй уялдсан бодит орон тоог батлан өгдөггүйгээс орон тоо жил бүр нэмэгдэн боловсон хүчний бодлого алдагдаж, халаа сэлгээ үргэлжлэх нөхцөл байдал үүсэж байна.
- Тус компани сонгон шалгаруулалтын зарчмаар агаарын тээврийн салбарын өндөр ур чадвартай, нарийн мэргэшсэн ажилтнуудаар хүний нөөцөө бүрдүүлэх, ажилтан бүрийн мэргэжил, ажлын бүтээмж, хариуцлага, ур чадварыг харгалзан чадварлаг баг бүрдүүлснээр хөдөлмөрийн бүтээмжийг тодорхой хувиар нэмэгдүүлж цалин хөлс урамшууллын илүү үр өгөөж бүхий тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай байна.
- Төлөөлөгчийн газрууд тийзийн орлогыг тухайн бүрд нь тушаадаггүй, орон тоо, төлөвлөгөөт зардлыг хэтрүүлсэн, удирдах болон бусад ажилтнуудыг гаднаас шууд томилдог нь дээрх алдаа зөрчил гарахад нөлөөлсөн, зарим төлөөлөгчийн газруудын билет борлуулагч нарын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй байна.
- Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй, 2017 онд хэрэгжсэн худалдан авалтаас 86 худалдан авах ажиллагааг нээлттэй



тендерээр зарлахаар төлөвлөсөн бөгөөд 24 нь бараа ажил үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт явуулалгүй шууд худалдан авсан байна.

- Хариуцсан хэлтэс тасгуудын ажлын уялдаа хангалтгүйгээс зарим бараа солилцооны болон худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилтэд тавих хяналт орхигдож, гарсан ажил гүйлгээг бүртгээгүй байна.
- Катерингийн үйлчилгээ үзүүлдэг компанитай байгуулсан гэрээнд тусгасан барьцаа хөрөнгийг буцаан олгосон, үндсэн гэрээний хугацаа дууссан байна.
- Агаарын хөлгийн өмчлөгч нь гэрээний үүргээ биелүүлээгүй атлаа 9.7 сая ам.долларыг нэхэмжилсэн байхад 3.0 сая ам.долларын эвлэрлийн гэрээ байгуулсан байна.
- Тус компанийн санхүүгийн үйл ажиллагаанд өмнө нь Сангийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Төрийн өмчийн хорооноос удаа дараа шалгалт хийгдэж байсан боловч үр дүн хангалтгүй, зөрчил дутагдал жил бүр дахин давтан гарсаар байна.
- Тийзийн хөнгөлөлт үзүүлэхдээ Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан холбогдох журмыг мөрдөхгүйгээр олгож байна.



ЗӨВЛӨМЖ

Шалгалтын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөмж болгож байна.

Нэг. Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэд,

- Үндэсний агаарын тээвэрлэгчийн эдийн засаг, санхүүгийн байдал мэдэгдэхүйц сайжрах, агаарын хөлгийн парк шинэчлэл нэмэгдэх, менежмент олон улсын жишигт хүрэх хүртэлх тодорхой хугацаанд нээлттэй агаарын харилцааны хэлэлцээрт болгоомжтой хандах, одоогийн хэлэлцээрээр тогтоосон багтаамж, давтамж, чиглэлийг өнөөгийн түвшинд хэвээр хадгалахад бодлогоор дэмжих замаар иргэний нисэхийн салбарт баримтлах бодлогын баримт бичгийг хэрэгжүүлж ажиллах.

Хоёр. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осорт,

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас тухайн оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлахдаа компанийн ирүүлсэн зорилтын санал, тоо мэдээлэл, судалгааг нарийвчлан хянан үзэх, үр дүн, үр ашгийн бодит үндэслэлийг тооцож байх,
- Компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг хууль тогтоомжуудтай нийцүүлэх, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн сонгох эрхийг хязгаарласан холбогдох заалтад өөрчлөлт оруулах талаар судлан үзэж санал боловсруулан холбогдох журмын дагуу шийдвэрлүүлэх,
- Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хийгдсэн удаа дараагийн шалгалтын үр дүнгийн хэрэгжилт хангалтгүй, зөрчил дутагдал давтан гарч байгаад анхаарч ажиллах.

Хоёр. “МИАТ” ТӨХК-ийн ТУЗ-ийн дарга Д.Даваасүрэнд,

- “МИАТ” ТӨХК-ийн үйл ажиллагааны менежмент, маркетингийн бодлого зохицуулалтыг бусад авиа компанитай өрсөлдөхүйц болгох, зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, үйлчилгээний шуурхай, уян хатан байдлыг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллах,
- Компанийн эдийн засгийн үзүүлэлтийн талаарх тоо мэдээлэл, судалгаа, үр ашгийн үндэслэлийг нарийвчлан хянан үзэх, нислэг үйлдвэрлэлийн хэмжээтэй уялдсан орон тоог бодитой гаргаж батлуулах,
- Компанийн үйл ажиллагаанд өмнө нь хийгдсэн шалгалтаар илэрсэн алдаа зөрчлүүд дахин давтан гарч байгаад анхаарч, түүний мөрөөр авсан арга хэмжээний хэрэгжилтийг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлдэг явдлыг хэвшил болгох, салбарын онцлог байдлыг харгалзан үзэж ТБОНӨХБАУХАТХууль болон бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах талаар судлан үзэж санал боловсруулан шийдвэрлүүлэх,
- Урт хугацаат зээлийн дарамтыг бууруулах зорилгоор компанийн үр ашгийн талаарх үндэслэл тооцоо судалгааг гаргаж Боинг767-300ER агаарын хөлгийн цаашдын үйл ажиллагааны цар хүрээ, ирээдүйн зах зээлд өрсөлдөх нөхцөл, худалдан борлуулж шинэ загварын агаарын хөлөг түрээслэх боломжтой эсэхийг судлан үзэж, санал боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөл, Иргэний нисэхийн ерөнхий газар, Зам тээврийн хөгжлийн яам зэрэг байгууллагатай хамтран Засгийн газарт холбогдох асуудлыг тавьж шийдвэрлүүлэх,
- Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх хэмжээний хүрээнд баталсан “МИАТ ТӨХК-ийн нислэгээр хөнгөлөлттэй тийзээр зорчих зөвшөөрөл олгох журам”-ыг боловсронгуй болгон мөрдүүлэх, Гүйцэтгэх захирал “Компанитай хамтран



ажилладаг харилцагч байгууллага, албан тушаалтнуудад хөнгөлөлттэй нөхцөлөөр нислэгийн тийз олгох журам”-ыг хүчингүй болгох,

- Засгийн газрын нөөц сангаас авсан зээлийн эргэн төлөлтөд 1.4 тэрбум төгрөгийн алданги тооцож байгаа нь үндэслэлтэй эсэхийг судлан үзэж ЗТХЯ, СЯ-тай хамтран шийдвэрлэх.

Гурав. “МИАТ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Т.Тамирт,

- Батлагдсан орон тоо жил бүр нэмэгдэж, боловсон хүчний бодлого алдагдаж буйг анхаарч халаа сэлгээ үргэлжлэх нөхцөлийг таслан зогсоох, хүний нөөцийн програм хангамжийг боловсронгуй болгох,
- Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавих,
- Төлөөлөгчийн газруудын тийзийн орлого, орон тоо, төлөвлөгөөт зардалд хяналт тавих ажлыг чангатгах,
- Хөрөнгө ашиглалтын менежментийг сайжруулж, бараа материалын оновчтой хэмжээг байнга тооцоолох, зохистой бага түвшинд байлгах, авлага цуглуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх,
- “Нүхт тур” ХХК-тай байгуулсан гэрээнд заасан барьцаа хөрөнгийг буцаан өөрийн дансанд байршуулах,
- Б.Эрдэнэбилэгтэй /гүйцэтгэх захирал асан/ холбоотой шүүхийн шийдвэрийн төлбөрийг барагдуулахаар БЗД-т байрлах 1016м² талбайтай агуулахын зориулалттай барилга, 9054м² газрын үнэлгээ үнэн зөв хийгдсэн эсэх түүнийг шийдвэрлэсэн болон хөрөнгөд тусгасан байдлыг дахин хянаж, залруулах.



Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 6 дугаар сарын 03 ны өдрийн /.../ дугаар тушаалын хосбодугаар хавсралт

Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Хариуцагч байгууллага	Зөрчлийн товч утга	Албан шаардлагын дугаар	Зөрчлийн дүн /сая төг/
1	"МИАТ" ТӨХК	Катеринг төвийн удирдлагын үндсэн гэрээний хугацаа дууссан байхад нэмэлт гэрээ гэрээ байгуулсан, барьцаа төлбөрийг үндэслэлгүйгээр буцаан олгосон байна.	2018.5.30 01/216	1,200.0
2	"МИАТ" ТӨХК	Хөнгөлөлттэй нөхцөлөөр хөнгөлөлтийн тийз олгох журмын 2.1-т "Энэхүү журмын 1.5, 1.7 дахь хэсэгт заасан хөнгөлөлттэй тийз хүсэх эрх бүхий албан тушаалтан, эрх бүхий ажилтан тэдгээрийн гэр бүлд жилд нэг удаа, ...олгоно" гэж заасныг зөсчиж, нэг хүнд 2-11 удаа хөнгөлөлт олгосон байна.	2018.5.30 01/215	562.5
	"МИАТ" ТӨХК	...журмын 1.7-д "Эрх бүхий ажилтан гэж МИАТ ХК болон салбар, төлөөлөгчийн газарт 3-аас доошгүй жил тасралтгүй ажиллаж буй ажилтныг" гэж заасныг мөрдөлгүй хугацаа нь хүрээгүй ажилтанд болон хамаарахгүй хүнд ч хөнгөлөлт олгосон байна.	2018.5.30 01/215	263.0
	"МИАТ" ТӨХК	...журмын 2.2-т "Тэтгэвэрт гарсан өндөр настанд хоёр жилд нэг удаа олон улсын нислэгт энгийн зэрэглэлийн суудлын 100 хүртэл хувийн тийзийн хөнгөлөлтийг суудлын боломжтой нөхцлөөр олгоно" гэж заасныг мөн зөрчиж зарим хүнд 2-3 удаа олгосон байна.	2018.5.30 01/215	3.3
	"МИАТ" ТӨХК	5.3-т "Гадны байгууллага, хувь хүнд олон улсын болон орон нутгийн нислэгийн чиглэлд энгийн зэрэглэлийн суудлын хөнгөлөлтгүй гарифаас тооцон 90 хүртэлх хувийн хөнгөлөлтийг хүсэлт гаргагчийн төлбөрийн чадвар, хүсэлт гаргасан шалтгаан, нөхцлийг харгалзан тийзийн хөнгөлөлт буюу дамжлагийг үзүүлж болно" гэж заасныг 46 удаа зөрчин 229 хүнд 100 хувийн хөнгөлөлтийн зөвшөөрөл олгосон байна.	2018.5.30 01/215	12.0
3	"МИАТ" ТӨХК	"МИАТ" ТӨХК-ийн ТУЗ-ийн 2015 оны 6 дугаар сарын 10-ны 10/15 дугаар тогтоолоор баталсан "МИАТ" ТӨХК-ийн нислэгээр хөнгөлөлттэй тийзээр зөрчих зөвшөөрөл олгох журам"-ын 2.8 дугаар заалтад "Хөнгөлөлтийг энэ журамд зааснаас өөр нөхцлөөр тогтоох эрх нь ТУЗ-д байна" гэж заасныг зөрчжээ.	2018.5.30 01/214	0.0
4	"МИАТ" ТӨХК	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 353.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 483.1 сая төгрөгийн бараа материалыг худалдан авсан байна.	2018.5.30 01/212	836.7
	"МИАТ" ТӨХК	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөсчин шууд гэрээ байгуулжээ. Тухайлбал, тус компани нь харуул хамгаалалтын ажил үйлчилгээг 2011 оноос хойш "Чин хутаг өндөр" ХХК-тай гэрээ байгуулан авч байсан бөгөөд 2017 оны худалдан авалтын	2018.5.30 01/212	8,165.7



		төлөөлөгөөнд тусгагдсан нээлттэй тендер шалгаруулалтаар худалдан авахдаа 595.6 сая төгрөгийн Хөшигийн хөндийн лоунжийн хөрөнгө оруулалтын төсвөөс 187.1 сая төгрөгийн шууд худалдан авалтыг тус тус хийсэн."Катерингийн үйлчилгээ үзүүлэх" арга хэмжээг тендер зарлалгүйгээр "Нүхт тур" ХХК-иар өмнөх гэрээг сунган хэрэгжүүлж 6,811.5 сая төгрөгийн зардал гаргасан байна. Мөн 571.4 сая төгрөгийн бусад шууд худалдан авалт хийсэн байна.		
5	"МИАТ" ТӨХК	Төлөөлөгчийн газрын ажилтнууд, менежер нь гүйцэтгэх ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн, тийзний дэс дугаарын дагуу орлогыг тушаадаггүйгээс хяналт тавих боломжгүй байдалд хүргэсэн тухай бүрд нь бүрэн тушаагаагүйгээс их хэмжээний өр үүссэн.	2018.5.30 01/213	1,370.6
	Нийт дүн			12,413.8




 ҮХАГ122



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолын хавсралт

“МИАТ” ТӨХК-ийн УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ





Орлогын бүрэлдэхүүнийг хүснэгтээр харуулбал

/сая төгрөг/

Орлогын төрөл	2016 оны гүйц	2017		Харьцуулалт		%		Борлуулалтад эзлэх хувь	
		төл	гүйц	төл	өмнөх он	төл	өмнөх он	2016	2017
Зорчигч тээвэрлэлтийн орлого	219,164.9	234,815.9	293,057.9	58,242.0	73,893.0	125	134	74.3	74.4
Ачаа тээвэрлэлтийн орлого	14,419.5	16,950.1	17,676.5	726.4	3,257.0	104	123	4.9	4.5
Захиалгат нислэгийн орлого	19,588.1	40,612.4	33,680.2	(6,932.2)	14,092.1	83	172	6.6	8.6
Интерлайны шимтгэлийн орлого	217.4		884.8	884.8	667.4		407	0.1	0.2
Нойтон түрээсийн орлого	14,199.0	7,346.5	18,882.6	11,536.1	4,683.6	257	133	4.8	4.8
Үндсэн үйл.а-ны орлогын дүн	267,588.9	299,724.9	364,182.0	64,457.1	96,593.1	122	136	90.7	92.5
Газрын үйлчилгээний орлого	11,933.4	8,589.1	11,200.2	2,611.0	(733.3)	130	94	4.0	2.8
Техник үйлчилгээний орлого	10,033.9	7,199.7	9,233.8	2,034.1	(800.0)	128	92	3.4	2.3
Шатахуун сумлагааны орлого	337.6	166.6	3.6	(163.0)	(333.9)	2	1	0.1	0.0
Онгоцон доторх борлуулалт	282.6	349.5	594.1	244.6	311.5	170	210	0.1	0.2
Бусад орлого	3,629.0	3,150.0	4,097.4	947.4	468.4	130	113	1.2	1.0
Үндсэн бус үйл.а-ны орлогын дүн	26,216.5	19,454.9	25,129.2	5,674.3	(1,087.3)	129	96	8.9	6.4
Нийт үйл.а-ны орлогын дүн	293,805.4	319,179.8	389,311.2	70,131.4	95,505.8	122	133	99.6	98.9
Үйл ажиллагааны бус орлогын дүн	1,096.66	440.00	4,488.56	4,048.6	3,391.9	40	1020	0.4	1.1
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	294,902.1	319,619.8	393,799.8	74,180.0	98,897.7	108	123	100.0	100.0

Хавсралт 3

Шатахууны худалдан авалтын статистик үзүүлэлтүүд

/тэрбум

төгрөг/

Гэрээний огноо	Батлагдсан төсөв		Нийлүүлэгч байгууллага	Гэрээгээр			Гүйцэтгэлээр			
	Нийт /Мян.төг/	Тоо /тонн/		Тоо /тн/	Нийт /мян.төг/	Нэгж Үнэ дундаж	Тоо /тн/	Нийт /мян.төг/	Нэгж үнэ дундаж	Өсөлт /бууралт/
2016.11.17	19,500.00	12.00	Мэргэван ХХК	12.0	8,679.0	723.3	12.4	19,662.1	1,591.3	54.5%
Нийт			12.0	8,679.0	723.3	12.4	19,662.1	1,591.3		
2017.11.18	27,084.92	13.50	Мэргэван ХХК	13.5	26,794.8	1,984.8	1.5	3,072.1	2,110.0	5.9%
Нийт			13.5	26,794.8	1,984.8	1.5	3,072.1	2,110.0		
НИЙТ	46,584.92	25.50		25.5	35,473.8		13.8	22,734.1		

Хавсралт 4

Шууд зардлыг хүснэгтээр харуулбал

/сая төгрөг/

Төрөл	2016 он			2017 он			Харьцуулалт			Нийт зардалд эзлэх хувь		Шууд зардалд эзлэх хувь	
	төл	гүйц	хэт/хэм	төл	гүйц	хэт/хэм	Өнгөрсөн оноос		төл хувь	2016	2017	2016	2017
							дүн	хувь					
Онгоцны шатах тослох материал	56,697.9	43,912.5	12,785.5	73,759.5	67,418.9	6,340.6	23,506.4	153.5	91.4	15.2	20.2	25.0	28.2
Буулт хөөрөлтийн хураамж	5,952.9	7,560.0	(1,607.1)	8,643.0	9,667.8	(1,024.8)	2,107.8	127.9	111.9	2.6	2.9	4.3	4.0
Газрын техникийн үйлчилгээ	13,579.4	14,413.3	(834.0)	14,470.0	16,860.0	(2,390.0)	2,446.7	117.0	116.5	5.0	5.0	8.2	7.1
Аэронавигацийн хураамж	14,001.4	14,097.4	(96.0)	17,125.9	17,167.1	(41.2)	3,069.6	121.8	100.2	4.9	5.1	8.0	7.2
Цалингийн зардал	7,602.9	9,395.2	(1,792.3)	10,107.2	13,535.4	(3,428.2)	4,140.2	144.1	133.9	3.3	4.1	5.4	5.7
ЭМНДШ-ийн шимтгэл	995.7	1,229.7	(234.0)	1,368.6	1,745.9	(377.3)	516.2	142.0	127.6	0.4	0.5	0.7	0.7
Хоолны зардал	190.0	448.0	(258.0)	-	698.7	(698.7)	250.7	156.0		0.2	0.2	0.3	0.3
Унаа, байрны зардал	612.5	521.6	90.8	-	769.3	(769.3)	247.6	147.5		0.2	0.2	0.3	0.3
Зорчигчийн хvнсний зардал	9,840.7	9,894.7	(53.9)	11,787.8	13,218.7	(1,430.9)	3,324.0	133.6	112.1	3.4	4.0	5.6	5.5
Зорчигчийн үйлчилгээний зардал	4,886.5	4,600.1	286.4	5,182.2	4,639.8	542.4	39.7	100.9	89.5	1.6	1.4	2.6	1.9
Томилолын мөнгө	1,885.5	2,623.9	(738.4)	4,968.0	3,984.2	983.9	1,360.3	151.8	80.2	0.9	1.2	1.5	1.7
Агаарын хөлгийн техникийн үйлчилгээ	15,924.6	24,341.7	(8,417.1)	29,359.1	41,229.6	(11,870.5)	16,887.9	169.4	140.4	8.4	12.3	13.9	17.3
Захиалгат нислэгийн зардал	-	7.2	(7.2)	-	-	-	(7.2)	-		0.0	-	0.0	-
Агаарын хөлгийн түрээс	24,421.3	25,798.3	(1,377.0)	33,086.8	36,291.2	(3,204.4)	10,492.9	140.7	109.7	8.9	10.9	14.7	15.2
Онгоцны даатгал	3,633.9	3,934.9	(300.9)	4,614.9	4,499.1	115.9	564.2	114.3	97.5	1.4	1.3	2.2	1.9
НБ, ИТА-ны Сургалтын зардал	2,584.2	2,797.4	(213.2)	3,456.7	4,050.8	(594.1)	1,253.4	144.8	117.2	1.0	1.2	1.6	1.7
Нойтон түрээсийн нислэгийн зардал	6,726.7	8,910.8	(2,184.1)	-	2,142.3	(2,142.3)	(6,768.5)	24.0		3.1	0.6	5.1	0.9
НБ-ийн томилолт	-	854.8	(854.8)	58.3	1,054.9	(996.6)	200.1	123.4	1,809.4	0.3	0.3	0.5	0.4
Шууд зардлын дүн	169,536.2	175,341.5	(5,805.4)	217,988.1	238,973.5	(20,985.4)	63,632.0	136.3	109.6	60.7	71.6	100.0	100.0

Хавсралт 5

Шууд бус зардлыг хүснэгтээр харуулбал

/сая төгрөг/

Төрөл	2016 он			2017 он			Харьцуулалт			Нийт зардалд эзлэх хувь		Шууд бус зардалд эзлэх хувь	
	төл	гүйц	хэт/хэм	төл	гүйц	хэт/хэм	Өнгөрсөн оноос		төл хувь	2016	2017	2016	2017
							дүн	хувь					
Цалингийн зардал	9,119.7	11,448.2	(2,328.5)	10,597.9	13,350.7	(2,752.8)	1,902.5	116.6	126.0	4.0	4.0	26.6	24.1
ЭМНДШ-ийн шимтгэл	1,237.6	1,518.9	(281.3)	1,431.9	1,696.9	(265.0)	178.0	111.7	118.5	0.5	0.5	3.5	3.1
Хоолны зардал	400.1	442.7	(42.6)	417.0	456.0	(39.0)	13.4	103.0	109.4	0.2	0.1	1.0	0.8
Нислэгийн саатал	337.4	786.4	(449.0)	364.5	786.1	(421.6)	(0.3)	100.0	215.7	0.3	0.2	1.8	1.4
Нис. тэнц. чад. гэрч. хураамж	97.2	74.0	23.2	97.0	491.8	(394.8)	417.7	664.3	507.0	0.0	0.1	0.2	0.9
Онгоц цэвэр-гээ, хангалт зардал	133.6	66.0	67.7	76.6	89.4	(12.8)	23.4	135.5	116.7	0.0	0.0	0.2	0.2
Ангарын түрээс	-	215.9	(215.9)	308.7	230.7	78.0	14.8	106.8	74.7	0.1	0.1	0.5	0.4
Онгоц, моторын элэгдэл	7,560.0	7,555.9	4.1	7,555.9	7,555.9	0.0	0.0	100.0	100.0	2.6	2.3	17.5	13.6
Дүрэмт хувцасны зардал	37.4	93.2	(55.8)	87.0	114.1	(27.1)	20.9	122.5	131.2	0.0	0.0	0.2	0.2
АТК хоорондын шимтгэл	1,268.7	1,269.4	(0.7)	1,192.8	1,835.0	(642.2)	565.6	144.6	153.8	0.4	0.5	2.9	3.3
Борлуулагч агентын шимтгэл	5,154.2	6,390.4	(1,236.2)	6,202.8	9,722.2	(3,519.4)	3,331.8	152.1	156.7	2.2	2.9	14.8	17.5
Интерлайны шимтгэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
СИТА суудал захиалгын зардал	8,990.9	6,865.0	2,125.9	10,916.0	10,946.4	(30.4)	4,081.4	159.5	100.3	2.4	3.3	15.9	19.8
Катерингийн ББӨ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Цайны газрын ББӨ	-	0.9	(0.9)	-	-	-	(0.9)	-	-	0.0	-	0.0	-
Худалдааны барааны өртөг	17.4	25.6	(8.3)	-	158.9	(158.9)	133.3	619.8	-	0.0	0.0	0.1	0.3
НБ-ын ГОМШӨ-ий даатгал	137.8	181.5	(43.7)	176.9	144.8	32.0	(36.7)	79.8	81.9	0.1	0.0	0.4	0.3
Кредит картны шимтгэл	184.2	356.1	(171.9)	332.0	684.0	(351.9)	327.9	192.1	206.0	0.1	0.2	0.8	1.2
Зар, сурталчилгааны зардал	316.7	1,017.2	(700.5)	903.2	1,198.5	(295.2)	181.3	117.8	132.7	0.4	0.4	2.4	2.2
Ном, гарын авлага, заавар	631.3	1,099.8	(468.4)	950.0	1,352.4	(402.4)	252.6	123.0	142.4	0.4	0.4	2.6	2.4
IASO-ийн зардал	79.1	0.1	79.0	200.0	159.6	40.4	159.6	192,120.4	79.8	0.0	0.0	0.0	0.3
Нислэгтэй холбоо тээв/ зардал	491.6	517.5	(25.9)	502.4	532.7	(30.3)	15.1	102.9	106.0	0.2	0.2	1.2	1.0
Хөдөлмөр хамгааллын зардал	48.6	154.7	(106.1)	79.1	36.1	43.0	(118.6)	23.3	45.6	0.1	0.0	0.4	0.1
Сувнер шопын өртөг	-	-	-	-	4.7	(4.7)	4.7	-	-	-	0.0	-	0.0
ББӨ-Үндсэн хөрөнгө	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ББӨ - Газрын үйлчилгээ	939.3	1,059.1	(119.8)	1,085.5	1,236.3	(150.9)	177.3	116.7	113.9	0.4	0.4	2.5	2.2
ББӨ - шатахуун	111.2	255.1	(143.9)	128.2	3.1	125.1	(252.0)	1.2	2.4	0.1	0.0	0.6	0.0
ББӨ-Бусад	864.2	1,710.4	(846.2)	1,233.7	2,629.2	(1,395.5)	918.8	153.7	213.1	0.6	0.8	4.0	4.7
Шууд бус зардлын дүн	38,158.0	43,103.7	(4,945.7)	44,839.2	55,415.3	(10,576.1)	12.3	128.6	123.6	14.9	16.6	100.0	100.0

Хавсралт 6

Ерөнхий удирдлагын зардлыг хүснэгтээр харуулбал

Төрөл	2016 он			2017 он			Харьцуулалт			Нийт зардал		Ерөнхий зардалд эзлэх	
	төлөвлөгөө	гүйцэтгэл	хэтрэлт, хэмнэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	хэтрэлт, хэмнэлт	Өнгөрсөн он		төлөвлөгөө хувь	2016	2017	2016	2017
							дүнгээр	хувь					
Цалингийн зардал	3,903.5	5,154.9	(1,251.4)	5,065.7	6,629.2	(1,563.4)	1,474.3	128.6	130.9	1.8	2.0	18.9	19.7
ЭМНДШ-ийн шимтгэл	538.0	712.5	(174.5)	637.4	825.5	(188.2)	113.0	115.9	129.5	0.2	0.2	2.6	2.4
Хоолны зардал	235.8	249.3	(13.5)	200.0	254.4	(54.4)	5.1	102.0	127.2	0.1	0.1	0.9	0.8
Томилолын зардал	851.8	1,497.6	(645.9)	990.0	1,983.9	(993.9)	486.3	132.5	200.4	0.5	0.6	5.5	5.9
Даатгал	16.4	25.8	(9.4)	29.1	25.0	4.1	(0.8)	96.9	85.8	0.0	0.0	0.1	0.1
Элэгдлийн зардал	1,510.0	1,573.3	(63.3)	1,501.3	1,571.0	(69.7)	(2.3)	99.9	104.6	0.5	0.5	5.8	4.7
Сургалтын зардал	520.1	229.4	290.8	1,458.1	663.8	794.3	434.4	289.4	45.5	0.1	0.2	0.8	2.0
Шагналын зардал	261.6	48.8	212.8	50.0	31.7	18.3	(17.1)	65.0	63.5	0.0	0.0	0.2	0.1
Урсгал засварын зардал	29.8	78.4	(48.7)	90.0	208.8	(118.8)	130.4	266.2	231.9	0.0	0.1	0.3	0.6
Цахилгаан эрчим хүч	193.1	288.3	(95.1)	226.0	364.7	(138.7)	76.4	126.5	161.4	0.1	0.1	1.1	1.1
Уур, ус, халаалт	154.4	182.6	(28.2)	179.1	179.9	(0.8)	(2.8)	98.5	100.4	0.1	0.1	0.7	0.5
Тээврийн зардал	300.0	656.6	(356.6)	177.1	815.9	(638.8)	159.3	124.3	460.6	0.2	0.2	2.4	2.4
Билет үнэт цаасны зардал	194.3	188.5	5.8	166.0	227.6	(61.5)	39.1	120.7	137.0	0.1	0.1	0.7	0.7
Шуудан холбооны зардал	156.6	362.5	(205.9)	170.2	444.5	(274.2)	82.0	122.6	261.1	0.1	0.1	1.3	1.3
Түрээсийн зардал	319.5	893.8	(574.3)	181.6	1,088.2	(906.6)	194.4	121.7	599.4	0.3	0.3	3.3	3.2
Сэлбэг хэрэгсэл, хангамж	112.3	80.8	31.5	70.0	84.6	(14.7)	3.8	104.7	120.9	0.0	0.0	0.3	0.3
Дохиолол, харуул.хамг зардал	355.2	420.6	(65.4)	482.6	541.5	(58.9)	120.9	128.7	112.2	0.1	0.2	1.5	1.6
Зөвлөгөө, үйлчилгээний зардал	435.0	802.6	(367.6)	582.7	2,277.9	(1,695.1)	1,475.3	283.8	390.9	0.3	0.7	2.9	6.8
Гэрээт үйлчилгээний хөлс	45.0	67.0	(22.0)	61.2	115.7	(54.5)	48.7	172.7	189.0	0.0	0.0	0.2	0.3
Татварын зардал	122.4	115.2	7.2	117.8	98.7	19.1	(16.5)	85.7	83.8	0.0	0.0	0.4	0.3
Баяр ёслолын зардал	360.0	345.5	14.5	350.0	295.0	55.0	(50.5)	85.4	84.3	0.1	0.1	1.3	0.9
ОУ ба ОН байгууллагын гишүүний	54.4	54.4	0.1	53.3	70.7	(17.3)	16.3	130.0	132.5	0.0	0.0	0.2	0.2
Хөнгөлөлт, тэтгэмжийн зардал	609.3	613.9	(4.5)	669.7	681.3	(11.7)	67.5	111.0	101.7	0.2	0.2	2.3	2.0
Гаалийн бүрдүмлэлтийн хураамж	-	0.1	(0.1)	0.6	-	0.6	(0.1)	-	-	0.0	-	0.0	-
Зээлийн хүү	10,883.9	12,040.6	(1,156.7)	13,514.0	12,001.2	1,512.8	(39.5)	99.7	88.8	4.2	3.6	44.2	35.6
Банкны шимтгэл	211.1	163.5	47.6	168.0	278.0	(110.0)	114.5	170.0	165.4	0.1	0.1	0.6	0.8
Конторийн хангамжийн материал	265.3	362.0	(96.7)	306.5	411.3	(104.8)	49.2	113.6	134.2	0.1	0.1	1.3	1.2
Конторын цэвэрлэгээ	5.0	20.6	(15.6)	3.5	20.6	(17.1)	0.0	100.1	594.2	0.0	0.0	0.1	0.1
Сав хэрэглэлийн зардал - Гуанз	-	0.6	(0.6)	-	2.0	(2.0)	1.4	331.5		0.0	0.0	0.0	0.0
Түрээсийн хүүгийн зардал	136.0	15.3	120.7	-	-	-	(15.3)	-		0.0	-	0.1	-
Найдваргүй авлагын зардал					1,513.9	(1,513.9)	1,513.9			-	0.5	-	4.5
Ерөнхий удирдлагын зардлын дүн	22,779.9	27,245.2	(4,465.3)	27,501.5	33,706.3	(6,204.8)	6,461.1	123.7	122.6	9.4	10.1	100.0	100.0



Хавсралт 7

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл

/сая төгрөг/

Д/д	Батлагдсанаар				Гүйцэтгэл					Худалдан авалтын зөвшөөрөгдсөн хэмжээ	Хэтрэлт
	№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөвт өртөг (сая.төгрөг)	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам	Биелсэн эсэх	Гэрээний дүн	Үндсэн хөрөнгө	Ажил	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам		
1	1.3.1	Шугамын техник үйлчилгээний микроавтобус /АХЗҮГ/	50.0	НТШ	тийм	45.5	45.5	-	НТШ ХТШ ГШБ	45.5	-
2	1.3.2	Бага оврын хосолсон хөдөлгүүртэй ачааны машин /АХЗҮГ/	25.0	НТШ	тийм	20.3	20.3	-	НТШ ХТШ ГШБ	20.3	-
3	1.3.3	Микро автобус /4 ширхэг/	240.0	НТШ	тийм	240.0	240.0	-	НТШ ХТШ ГШБ	240.0	-
4	1.3.4	Дунд оврын автобус / 2 ширхэг /	240.0	НТШ	тийм	234.0	234.0	-	НТШ ХТШ	234.0	-
5	1.3.5	Катерингийн автомашин 1 шир /for B-747 aircraft/	650.0	НТШ	тийм	640.0	640.0	-	НТШ ХТШ	640.0	-
6	1.3.6	Аж ахуйн хэрэгцээнд зориулж ачааны автомашин авах 1 ширхэг	20.0	НТШ	тийм	21.0	21.0	-	НТШ ХТШ ГШБ	20.0	1.0
7	1.6.3	Зорчигчийн үйлчилгээний бүртгэлийн цогц системийг шинэчлэх PSS (Passenger Service Solution)	2,000.0	НТШ	тийм	2,000.0	-	2,000.0	шха	2,000.0	-
8	1.6.4	Мэдээллийн сангийн Оракл программын лиценз (Oracle 12c database server)	250.0	НТШ	тийм	245.3	135.9	245.3	ШХА	245.3	135.9
9	1.6.13	Нислэг зохицуулалтын төвийн нислэг үйлдвэрлэлийн зорилгоор ашиглаж буй телефон аппаратыг ашиглахад хялбар системээр солих	9.8	ШХА	тийм	9.6	17.5	3.4	ШХА	9.6	11.2
10	1.16.1	Хэвлэх төхөөрөмж Mimaki JV33 -160 inkjet series	37.5	ХА	тийм	35.2	35.2	-	ШХА	35.2	-
11	1.16.3	Агаарын хөлгийн их биеийн эвдрэл гэмтлийг шалгах оношлох төхөөрөмж /GO/NO-GO 3D digital dent mapping/	165.0	НТШ	тийм	171.5	-	171.5	ШХА	165.0	6.5
12	1.16.4	Даралтат агаарын компрессор SK-20	9.8	ШХА	тийм	8.8	8.8	-	ШХА	8.8	-
13	1.16.8	Үл эвдэх сорилын цехийн стандарт болон шалгах багажны мэдрэгчүүд	25.0	ХА	тийм	18.5	-	18.5	ШХА	18.5	-
14	1.16.11	Агаарын хөлгийн хөдөлгүүрийн далд эд ангид үзлэг хийх видео төхөөрөмж	20.0	ХА	тийм	20.0	20.0	-	ШХА	20.0	-
15	1.18.9	В-737, В-767 онгоцны хаалга, зорчигчийн салоны хэсэг	367.9	НТШ	тийм	-	230.6	-	ШХА	230.6	-
16	2.1.1	Төв байрны харуулын байрны халаалтын шугам шинээр татах 54 у/м	22.0	ХА	тийм	17.5	17.5	-	ХА	17.5	-
17	2.1.3	Ажилчдын зоогийн газрын барилгын болон дээврийн засвар	61.0	ХА	тийм	49.9	48.6	1.3	ХА	49.9	-
18	2.1.4	Хөргөлттэй агуулахын шалны болон бусад засвар	30.0	ШХА	тийм	-	-	12.9	ШХА	12.9	-
19	2.1.5	Инженерийн шугам сүлжээний өвөлжилтийн бэлтгэл ажилд	30.0	ШХА	тийм	-	8.5	-	ШХА	8.5	-
20	2.1.6	Спорт заалны гадна ус дулааны шугамын засвар 115 у/м	58.8	ХА	тийм	49.1	49.1	-	ХА	49.1	-
21	2.3.1	Лонж зураг төсөв, төнөг төхөөрөмж	300.0	НТШ	тийм	187.1	68.7	118.4	ШХА	187.1	-
22	2.3.1	Бренд хөгжүүлэлтийн хөрөнгө оруулалт	420.0	НТШ	тийм	218.0	-	104.4	НТШ	218.0	-
НИЙТ			5,031.8			4,231.3	1,841.2	2,675.7	-	4,475.8	154.6



Хавсралт 8

Төлөвлөгөөгүйгээр худалдан авсан үндсэн хөрөнгө

/сая төгрөг/

Харилцагч нэр	Хөрөнгийн данс						НИЙТ
	Барилга байгууламж	Машин тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, ХТТ	Биет бус хөрөнгө	
	2103	2104	2105	2106	2107	2201	
Ай Ти Зон ХХК	-	-	-	-	27.1	-	27.1
Изинис-эйрвэйз ХХК	-	0.8	-	-	-	-	0.8
Элмонте ХХК	-	-	-	-	1.2	-	1.2
Киберком ХХК	-	-	-	-	9.3	-	9.3
Сорос компьютер ХХК	-	-	-	-	2.9	-	2.9
Саммит компьютер технологи ХХК	-	-	-	-	135.9	-	135.9
Авто ойл ХХК	-	0.8	-	-	-	-	0.8
Би Си Ти ХХК	-	-	-	-	9.3	-	9.3
Синус-дочи ХХК	-	10.0	-	-	-	-	10.0
Тим Топ Зон ХХК	-	-	-	-	8.7	-	8.7
БСБ Электроникс ХХК	-	-	-	-	4.2	-	4.2
Моогол Клоуд ХХК	-	-	-	-	-	7.7	7.7
Ай Ти Сервис ХХК	-	-	-	-	6.3	-	6.3
Соларстар ХХК	-	-	-	-	1.8	-	1.8
Сүү Хүнгий ХХК	-	-	-	-	1.0	-	1.0
Пирст Пиксэл ХХК	-	-	-	-	9.7	-	9.7
И сет инженеринг ххк	-	2.1	-	-	-	-	2.1
Гранд Макс ХХК	-	-	-	0.5	-	-	0.5
БСБ Трейдинг ХХК	-	-	-	32.2	-	-	32.2
Немон Хийц ХХК	5.3	-	-	-	-	-	5.3
Эталон комфорт ХХК	-	-	-	7.5	-	-	7.5
Би эл ти трейд ХХК	1.8	-	-	-	-	-	1.8
Уянга Ерэнтэйн	-	-	-	-	3.8	-	3.8
Санко маркетинг монголиа ХХК	-	-	-	-	10.0	-	10.0
Эн Си Эс Эс ХХК	-	-	-	-	1.6	-	1.6
Алтан очир энд голд стар ХХК	-	-	-	-	9.8	-	9.8
Гранд монгол групп ХХК	-	-	-	-	23.1	-	23.1
Монхор хээр ХХК	-	2.7	-	-	-	-	2.7
Дунд завагт ХХК	-	-	1.5	-	-	-	1.5
Их колорфул ХХК	-	-	-	-	2.6	-	2.6
Жойнтстэйт констракшн ХХК	1.3	-	-	-	-	-	1.3
Saturn	-	-	-	-	0.3	-	0.3
Media Mark TV-Hifi-Elektro GMBH	-	-	-	-	0.7	-	0.7
Бүрэг Хангайн Нуруу ХХК	-	2.4	-	-	-	-	2.4
Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар ТӨҮГ	-	-	-	8.0	-	-	8.0
НИЙТ	8.4	18.7	1.5	48.2	269.1	7.7	353.6

Хавсралт-8.1

Төлөвлөгөөгүйгээр худалдан авсан бараа, материал

/сая төгрөг/

Д/д/	Харилцагч байгууллага	Бараа материал	Дүн
1	Asiana Airlines	DIS хөлдөхөөс хамгаалсан шингэн	41.2
2	Scneider Co.,ltd	Архи, вино	187.5
3	Neofashion Europa GmbH	Хувцас	35.5
4	TREQUARTISTA	DIS хөлдөхөөс хамгаалсан шингэн	11.2
5	Батбайгаль ХХК	Жигнэмэг	12.5
6	Clariant Japan Co.Ltd	DIS хөлдөхөөс хамгаалсан шингэн	44.2
7	Үлэмж grosерс ХХК	Гурил будаа	12.4
8	Моттоо ХХК	Бэлэг дурсгалын бараа	51.0
9	Просум интернэйшнл ХХК	Ус ундаа	87.4
НИЙТ			483.1



ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРУУДЫН ЗАРДЛЫН ТООЦОО																						
Д/д	Зардлын төрөл	Хонконг			Берлин			Бээжин			Сөүл			Токио			Москва			НИЙТ		
		төл	гүйц	хэт/хэм	төл	гүйц	хэт/хэм	төл	гүйц	хэт/хэм	төл	гүйц	хэт/хэм	төл	гүйц	хэт/хэм	төл	гүйц	хэт/хэм	төл	гүйц	хэт/хэм
1	Цалин, хангамж	247.4	317.4	(70.0)	397.8	484.2	(86.4)	359.5	393.5	(34.1)	558.0	691.0	(132.9)	355.4	408.4	(52.9)	300.0	367.4	(67.4)	2,218.2	2,661.9	(443.8)
2	ЭМД ба НДШимтгэл	4.3	6.7	(2.4)	8.6	12.3	(3.7)	8.6	13.1	(4.5)	12.7	17.7	(5.0)	6.5	11.0	(4.5)	6.5	11.0	(4.6)	47.3	71.9	(24.6)
3	Ажлын байрны түрээсийн зардал			-	92.5	94.9	(2.4)	71.0	195.4	(124.4)	133.7	137.3	(3.6)	196.5	185.6	10.9	236.1	200.4	35.7	729.8	813.6	(83.8)
4	Тээврийн зардал	27.1	52.9	(25.8)	34.6	176.4	(141.8)	94.2	171.2	(77.0)	47.1	104.5	(57.4)	211.4	129.9	81.6	29.6	28.5	1.2	444.1	663.3	(219.3)
5	Ажлын байрны хангалт, үйлчилгээ	8.1	8.8	(0.7)	34.9	47.9	(13.0)	71.3	91.3	(20.1)	37.3	49.3	(12.0)	64.7	57.8	6.8	18.3	19.6	(1.3)	234.5	274.7	(40.1)
6	Албан томилолтын зардал		0.3	(0.3)	-	-	-	3.6	(3.6)	-	17.3	(17.3)	19.3	25.4	(6.1)	-	2.3	(2.3)	-	19.3	48.8	(29.5)
7	Зар сурталчилгааны зардал			-	-	-	-	-	-	-	14.5	(14.5)	72.2	29.7	42.6	-	-	-	-	72.2	44.2	28.1
8	Уулзалт, хэлэлцээрийн зардал		2.5	(2.5)	-	5.7	(5.7)	-	8.6	(8.6)	-	11.3	(11.3)	9.6	70.2	(60.5)	-	-	-	9.6	98.3	(88.6)
9	Баяр, ёслолын зардал			-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
10	Гадаадын иргэний шимтгэл			-	-	-	-	-	-	-	15.4	25.6	(10.2)	-	-	-	-	-	-	15.4	25.6	(10.2)
11	Аудитын үйлчилгээний зардал			-	-	-	-	-	-	-	10.2	10.0	0.1	15.6	8.3	7.3	7.2	16.8	(9.6)	33.0	35.1	(2.1)
12	Болзошгүй тохиолдлын зардал		8.7	(8.7)	-	1.7	(1.7)	-	17.8	(17.8)	-	-	-	-	-	-	-	-	-	-	28.3	(28.3)
13	ЗАРДЛЫН ДҮН	286.9	397.3	(110.4)	568.4	823.1	(254.7)	604.6	894.6	(290.0)	814.4	1,078.4	(264.0)	951.3	926.2	25.0	597.7	646.0	(48.3)	3,823.3	4,765.6	(942.3)



Зардлаар бүртгээгүй ажил, гүйлгээ

/сая төгрөг/

№	Харилцагч компани, хувь хүн	МИАТ-аас үзүүлсэн үйлчилгээ	Харилцагчийн үзүүлсэн үйлчилгээ	Зардлаар бүртгээгүй дүн	Зөрчлийн утга
1	“Нью тур сафарис” ХХК	21.2	21.2	21.2	Гэрээгүй
Гэрээгүй нийт		21.2	21.2	21.2	
2	Б.Номинтуяа	4.4	4.4	4.4	Хөрөнгө бүртгээгүй
3	Шилэн хийц	-	1.4	1.4	Хөрөнгө бүртгээгүй
Хөрөнгө нийт		4.4	5.8	5.8	
4	Хурд хамтлаг	11.4	11.4	11.4	2016,2017 онд зардал бүртгээгүй
5	“Номадс Хоспиталити” ХХК	23.1	23.1	23.1	Шинэ жилийн баярын арга хэмжээ
6	Х.Бархүү	5.8	5.8	5.8	2016 оны шинэ жилийн арга хэмжээ
7	Э.Ууганбаяр	23.5	23.5	23.5	2016 оны шинэ жилийн арга хэмжээ
8	Ц.Чулуунбат	8.8	8.8	8.8	Шинэ жилийн баярын арга хэмжээ
9	Д.Баттөмөр	1.0	1.0	1.0	Арга хэмжээний зардал бүртгээгүй
Арга хэмжээ зардал нийт		73.6	73.6	73.6	
10	Монголын Телевизүүдийн холбоо ТББ	14.9	14.9	14.9	Зар сурталчилгаа
11	“Радиоком Монгол” ХХК	14.4	14.4	14.4	Зар сурталчилгаа
12	Open Door	0.4	0.4	0.4	Зар сурталчилгаа
13	Global Insight Media	50.3	50.3	50.3	Зар сурталчилгаа
14	Төгөлдөр Урлаг ТББ	5.6	5.6	5.6	Зар сурталчилгаа
15	Монголын хэвлэл мэдээллийн маркетингийн холбоо	8.0	8.0	8.0	Зар сурталчилгаа
16	“Медиа боловсрол суваг” ХХК	13.1	13.1	13.1	Зар сурталчилгаа
17	“Очир пресс” ХХК	9.4	7.2	7.2	Зар сурталчилгаа
18	“Эс Пи Эс Эйч Ди” ХХК	7.1	7.1	7.1	Зар сурталчилгаа
19	“Орлоо инфо” ХХК	6.3	6.3	6.3	Зар сурталчилгаа
20	The mongolian mining journal	10.0	10.0	10.0	Зар сурталчилгаа
21	“Хүслийн өнгө” ХХК	4.5	4.5	4.5	Зар сурталчилгаа
22	“Нэйшнл Ньюс Корпорэйшн” ХХК	220.0	331.7	111.7	Зар сурталчилгаа
23	“Гранд степп” ХХК	4.5	75.2	70.7	Зар сурталчилгаа
Зар сурталчилгааны зардал нийт		368.5	548.7	324.2	
24	Мэдээлэл Технологийн Үндэсний Парк	1.4	1.4	1.4	Сургалтын зардал
25	Монголын мэргэжлийн нүүр хувиргагч төгс үзэсгэлэнт	2.7	2.7	2.7	Сургалтын зардал
Сургалтын зардал нийт		4.1	4.1	4.1	
26	“Өдрийн мэдээ” ХХК	9.6	9.6	9.6	Шуудан холбооны зардал
Шуудан холбооны зардал нийт		9.6	9.6	9.6	
27	“Интеркюзин” ХХК	1.2	1.2	1.2	Бусад зардал
Бусад зардал нийт		1.2	1.2	1.2	
28	Монгол Солонгосын ЭЗ форм	8.7	8.7	8.7	Хандив тусламжийн зардал
Хандив тусламжийн зардал нийт		8.7	8.7	8.7	
Нийт дүн		491.3	672.9	448.4	





ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.